ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр Дугаар A/12 Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /СНАГ-2023/02-НА-СТА/ тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумьяабазар)-д зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг гүйцэтгэл-нийцлийн хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлсүгэй.

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАХ-ний 90% төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс 71%-ийн хэрэгжилт удааширсан, ТАХ-ний бодит гүйцэтгэлд үндэслээгүй 9,553.5 сая төгрөгийн илүү санхүүжилт олгожээ.



**АУДИТЫН СЭДЭВ: “УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

Улаанбаатар хот
2023 он

СНАГ-2023/02-НА-СТА

Аудитын тайланг бэлтгэсэн:

Нийслэл дэх Төрийн аудитын газар
Гүйцэтгэл-Нийцлийн аудитын хэлтэс

Хэлтсийн дарга, аудитын менежер:
Э.Мөнхмандах

Аудитын менежер:
Б.Номинбаатар

Ахлах аудитор:
Ж.Жавзанпагма

Аудитор:
З.Болд
Г.Чулуунцэцэг
З.Баярбилэгт

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө “Г” корпус, Утас: 327787

Тайланг НТАГ-ын **http://audit.mn/** веб сайтаас үзнэ үү.


| | |
|---|---|
| Товчилсон үг | 2 |
| Хүснэгтийн жагсаалт | 3-3 |
| Хавсралтын жагсаалт | |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл | 4 |
| Бүлэг 1. А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн үү? | 5 |
| А.1 Төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу? | 5-9 |
| А.2 Төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү? | 9-13 |
| Бүлэг 2. Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцэж байна уу? | 14 |
| Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу? | 14-21 |
| Б.2 Төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу? | 21-27 |
| Б.3 Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон уу? | 28-29 |
| Б.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу? | 29-30 |
| Б.5 Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу? | 30-33 |
| Аудитын дүгнэлт | 34 |
| Аудитын зөвлөмж | 35 |
| Хавсралтууд | 36-46 |

## Товчилсон үг

| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
|---|---|
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНД | Багануур дүүрэг |
| БОАЖС | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| БШУС | Боловсрол шинжлэх ухааны сайд |
| БХБС | Барилга, хот байгуулалтын сайд |
| ДЗД | Дүүргийн Засаг дарга |
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| ЗГ | Засгийн газар |
| ЗД | Засаг дарга |
| ЗТХС | Зам тээвэр, хөгжлийн сайд |
| МУ | Монгол Улс |
| НЗХГ | Нийслэлийн Замын хөгжлийн газар |
| НБГ | Нийслэлийн Боловсролын газар |
| НД | Налайх дүүрэг |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НӨХГ | Нийслэлийн Өмчийн харилцааны газар |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НХААГ | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар |
| НХБХГ | Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар |
| НХОГ | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар |
| НОСБГ | Нийслэлийн Орон сууцны бодлогын газар |
| СС | Сангийн сайд |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТШӨХ | Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үндэслэл |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| УБЗАА | Улаанбаатар Захирагчийн ажлын алба |
| УИХ | Улсын Их Хурал |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ХХААХҮС | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд |
| ХНХС | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| ХЗДХС | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

## Хүснэгтийн жагсаалт


| Дугаар | Гарчиг | Хуудас |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байдал | 5-6 |
| Хүснэгт 2 | Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдсан байдал | 6-7 |
| Хүснэгт 3 | МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уялдсан байдал | 8-9 |
| Хүснэгт 4 | Шинээр төлөвлөгдсөн ТАХ-ний эдийн засгийн ангиллаар | 9 |
| Хүснэгт 5 | Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ | 10-11 |
| Хүснэгт 6 | 2022 оны төсвийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ | 12 |
| Хүснэгт 7 | Хэмнэлтийн тухай хуульд хориглосон ТАХ-ний жагсаалт | 13 |
| Хүснэгт 8 | Эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо | 14-15 |
| Хүснэгт 9 | ТЕЗ-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа | 15 |
| Хүснэгт 10 | НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа | 15 |
| Хүснэгт 11 | ХАА-г зохион байгуулахад зарцуулсан хугацаа | 16 |
| Хүснэгт 12 | Боловсруулсан тендерийн баримт бичиг | 17 |
| Хүснэгт 13 | Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ | 21-22 |
| Хүснэгт 14 | Газрын байршил тодорхойгүй, өөрчлөгдсөн ТАХ-ний жагсаалт | 24-25 |
| Хүснэгт 15 | Тоног төхөөрөмж нийлүүлсэн ТАХ | 26 |
| Хүснэгт 16 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан хэрэгжилт удааширсан ТАХ | 26-27 |
| Хүснэгт 17 | Үнийн индекс тооцуулсан, нэмэлт санхүүжилт гэрээ байгуулсан ТАХ | 29 |
| Хүснэгт 18 | Хэрэгжиж дууссан ТАХ | 31 |
| Хүснэгт 19 | Гэрээний үүргийн биелэлт тооцсон ТАХ | 31 |
| Хүснэгт 20 | Өмч бүртгэл | 32 |


## Графикийн жагсаалт


| Дугаар | Гарчиг | Хуудас |
|---|---|---|
| График 1 | Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ | 11 |
| График 2 | ХАА-г зохион байгуулсан журам | 19 |
| График 3 | ТАХ-нд эзлэх хувийн жин, төрлөөр | 20 |


## Хавсралтын жагсаалт


| Дугаар | Гарчиг | Хуудас |
|---|---|---|
| Хавсралт 1 | Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй ТАХ | 40 |
| Хавсралт 2 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр ХАА-г зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт | 41 |
| Хавсралт 3 | ТББ-т тусгасан зарим шаардлага хангаагүй гүйцэтгэгчдийн жагсаалт | 42-44 |
| Хавсралт 4 | Бодит гүйцэтгэлд үндэслэлгүй илүү санхүүжилт олгосон ТАХ-ний жагсаалт | 45-47 |
| Хавсралт 5 | Үнийн өсөлтийн санхүүжилт авах нэмэлт гэрээ байгуулах төсөл арга хэмжээний мэдээлэл | 48-49 |

| | |
|---|---|
| | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл |
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх | Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу НТАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв. |
| Аудитын зорилт | Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн.<br>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;<br>- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх; |
| Аудитын хамарсан хүрээ | Аудитыг НЗДТГ, НХААГ, НХБХГ, НЗХГ, “НХОГ” ОНӨААТҮГ, холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ. |
| Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт | Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. |
| Аудитын бүрэлдэхүүн, хугацаа | Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах, аудитын менежер Б.Номинбаатар нар хянан удирдаж, аудитын багийг ахлах аудитор Ж.Жавзанпагма ахалж, аудитор З.Болд, Г.Чулуунцэцэг, З.Баярбилэгт нар гүйцэтгэв.<br>Аудитыг 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэв. |

## БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

УИХ-аас 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтад "Монгол улсын 2022 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж"-ийн жагсаалтыг баталснаас холбогдох яамдын ТЕЗ-даас 455,728.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 187 ТАХ эрх шилжиж ирснээс шинээр хэрэгжих 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ, шилжих 249,692.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 115 ТАХ-г НЗД-д эрх шилжүүлжээ.

### А.1 Төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д шинээр хэрэгжүүлэхээр багцад хуваан эрх шилжүүлсэн 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

### А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-той нийцэж байна уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д шинээр хэрэгжүүлэхээр багцад хуваан эрх шилжүүлсэн 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ нь УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дараах байдлаар тусгагджээ.

**Хүснэгт №1.Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байдал**

| Д/д | Бодлогын баримт бичгийн зорилго | Зорилтын зүйл, заалт | Хамрагдсан ТАХ- ний тоо |
|---|---|---|---|
| 1 | Хүнд ээлтэй амьдрах орчин | Зорилт 2.5.Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана. | 26 |
| 2 | Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг | Зорилт 3.5.Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ заалтад хамаарагдах.<br>5.Ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулсан байна заалтад | 1 |
| 3 | Хүн төвтэй хот | Зорилт 9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг суралцагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан цогц хөгжлийн төв болгон хөгжүүлнэ гэсэн заалтад | 27 |
| 4 | Үнэт баялаг ус | Зорилт 6.3.Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 3 |
| 5 | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд | Зорилт 4.2.Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.<br>8.Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна заалтад хамаарах | 4 |
| 6 | Төлөвлөлт төвтэй хөгжил | Зорилт 9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө<br>2.Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамж нэмэгдсэн байна гэсэн заалтад | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Орчин тэвтэй шийдэл | Зорилт 9.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно. | 2 |
| 8 | Эрүүл мэнд | Зорилт 2.2.Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.<br>2.Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна гэсэн заалтад | 6 |
| 9 | Боловсрол | Зорилт 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ гэсэн заалт | 1 |
| 10 | Тогтвортой хөдөө аж ахуй | Зорилт 8.3.Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ | 1 |
| | Нийт | | **72** |

**Дүгнэлт:** Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 72 ТАХ нь “Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

## А.1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөсөн үү?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д шинээр хэрэгжүүлэхээр багцад хуваан эрх шилжүүлсэн 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ нь УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хавсралт баримт бичиг болох Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дараах байдлаар тусгагджээ.

**Хүснэгт №2. Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдсан байдал**

| Д/д | Бодлогын баримт бичгийн зорилго | Зорилтын зүйл, заалт | Хамрагдсан ТАХ- ний тоо |
|---|---|---|---|
| 1 | Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг | Зорилт 3.5.Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ<br>3.5.2.иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ гэсэн заалт | 14 |
| 2 | Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) | Зорилт 5.3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ<br>5.3.3.төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал буурсан, үйлчилгээний үр дүн сайжирна заалтад | 1 |
| 3 | Гэр бүл | Зорилт 2.3.Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ:<br>2.3.4.хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана гэсэн заалт | 1 |
| 4 | Хүн төвтэй хот | Зорилт 9.1.Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:<br>9.1.1.нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна гэсэн заалтын | 5 |
| 5 | Үнэт баялаг ус | Зорилт 6.3.Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ:<br>6.3.1.усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.<br>6.3.2.газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, | 3 |

| | | | |
|---|---|---|---|
| | | томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхэлнэ.<br>6.3.3.нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангасан байна гэсэн заалт | |
| 6 | Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес | Зорилт 3.3.Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ:<br>3.3.4.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ гэсэн заалт | 1 |
| 7 | Орчин төвтэй шийдэл | Зорилт 9.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно<br>9.2.4.олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ заалтад | 1 |
| 8 | Төлөвлөлт төвтэй хөгжил | Зорилт 9.3.Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:<br>9.3.2.хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ гэсэн заалтад | 9 |
| 9 | Боловсрол | Зорилт 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ:<br>2.1.1.сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.<br>2.1.8.газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ гэсэн заалтад | 19 |
| 10 | Тогтвортой хөдөө аж ахуй | Зорилт 8.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:<br>8.3.13.хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, малын үүлдэр, угсааг сайжруулах, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэгчдийг дэмжих “Шинэ хөдөө” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэсэн заалтад | 2 |
| 11 | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд | Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:<br>4.2.8.цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана гэсэн заалт | 3 |
| 12 | Эрүүл мэнд | Зорилт 2.2.Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ:<br>2.2.1.халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.<br>2.2.2.хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.<br>2.2.3.оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ гэсэн заалт | 13 |
| | **Нийт** | | **72** |

**Дүгнэлт:** Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 72 ТАХ нь МУ-ын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт уялдсан байна.

### А.1.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь бодлогын зорилго, зорилтыг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг бий болгож байна уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д шинээр хэрэгжүүлэх 72 ТАХ нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах дараах байдлаар тусгагджээ.

**Хүснэгт №3. МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уялдсан байдал**

| Д/д | Бодлогын баримт бичгийн зорилго | Зорилт | Хамрагдсан ТАХ- ний тоо |
|---|---|---|---|
| 1 | Биеийн тамир, спорт | 2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ<br>2.2.3.Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина | 2 |
| 2 | “Цахим Монгол”- төрийн шуурхай үйлчилгээ | 4.1.1.Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна | 1 |
| 3 | Хөдөлмөр, нийгмийн хамгаалал | 2.5.8.Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ | 1 |
| 4 | Амар тайван, аюулгүй нийгэм | 4.3.3.Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана заалт | 13 |
| 5 | Аялал жуулчлал | 3.4.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.<br>3.4.4.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ | 1 |
| 6 | Барилга, хот байгуулалт | 3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.<br>3.7.11.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.<br>3.7.12.Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэсэн заалт | 15 |
| 7 | Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ<br>6.1.3.Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ гэсэн ажил,<br>6.1.7.Олон улсын стандартад нийцсэн явган хүний болон унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулан, тоосжилтыг 50 хувь бууруулна гэсэн заалт | 3 |
| 8 | Боловсрол | 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.<br>2.3.8.“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.<br>2.3.9.Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ<br>2.3.10.Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана гэсэн заалтад | 24 |
| 9 | Улаанбаатар | 6.2.Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ гэсэн заалт | 1 |
| 10 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр | 3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| | | хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ гэсэн заалт | |
| 11 | Эрчим хүч | 3.5.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана | 2 |
| 12 | Эрүүл мэнд | 2.1.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ<br>2.1.4.2.эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана заалтад | 8 |
| ***Нийт*** | | | **72** |

**Дүгнэлт:** Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 72 ТАХ нь ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд уялдсан байна.

## А.2. Төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих багц болж задраагүй 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ-ний 90% нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй, хөрөнгө оруулалтын ТАХ-нд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримтлан ажилласан байна.

### А.2.1. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас 184,859.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 ТАХ буюу 89.7% нь дэд бүтэц, барилга байгууламж, тохижилт зэрэг тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтын ТАХ байна.

**Хүснэгт №4. Шинээр төлөвлөгдсөн ТАХ-ний эдийн засгийн ангиллаар**

**сая.төг**

| Ангилал | Төсөвт өртөг | Тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| Дэд бүтэц | 13,834.5 | 6 | 6.7 |
| Барилга байгууламж | 134,278.3 | 32 | 65.2 |
| Тохижилт, гэрэлтүүлэг | 11,656.7 | 6 | 5.7 |
| Зураг төсөв, ТЭЗҮ | 500.0 | 1 | 0.2 |
| Их засвар | 21,176.0 | 12 | 10.3 |
| Тоног төхөөрөмж | 24,590.0 | 15 | 11.9 |
| **Нийт** | **206,035.5** | **72** | **100.0** |

Үүнээс 21,176.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын 12 ТАХ-ний 85.6% буюу 18,126.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй буюу хувийн өмчлөлийн хөрөнгийг сайжруулах, сэргээн засварлах ТАХ байна. Тухайлбал:

- Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 2, 30, 31 дүгээр байр/
- Нийтийн эзэмшлийн орон сууцны засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 05, 06, 07 дугаар байр, 5 дугаар хороо, Эрэл 47/1, 47/2, 47/3 дугаар байр, 17 дугаар хороо, Ганти 40, Ганти 40В дүгээр байр/
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны их засвар, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ Багц-1 СБД, 2-р хорооны 32-р байр, 1а-р байр. *Хавсралт №1*






**Дүгнэлт:** Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжсэн 72 ТАХ-ний 89.7% тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой ТАХ-г төлөвлөж, 10.3% нь өмчлөлд шилжих боломжгүй ТАХ байна.

### А.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлэгдэж, эрэмбэлэгдсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой, үр дүнтэй болох нь тогтоогдсон уу?

ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1[1]-ийн 2.1.1[2]-т заасны дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ нь холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлэгдэж, эрэмбэлэгдсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой, үр дүнтэй эсэхийг тооцох чиг үүрэг бүхий байгууллага нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж буюу ТЕЗ-дын эрхлэх хүрээний асуудал байх тул аудитын зорилтод хариулах боломжгүй болно.

### А.2.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгасан уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ-ээс 5,590.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ хүчингүй болж, 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний гэрээ байгуулагдаагүй, харин 200,295.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 ТАХ хэрэгжсэн бөгөөд үүнээс 175,305.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 ТАХ нь барилга байгуулж, их засвар, ИШС, тохижилт буюу зурагтай байх шаардлагатай ажил байна.

**Хүснэгт №5. Зураггүй ТАХ**

сая.төг

| № | Эрх шилжүүлсэн ТЕЗ | дүн | | Зураг, төсөв шаардлагатай ажил | | Зураггүй ажил | | Зурагтай ажил | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо |
| 1 | БХБЯ | 67,719.5 | 27 | 66,919.5 | 25 | 65,669.5 | 24 | 1,250.0 | 1 |
| 2 | БШУЯ | 96,575.0 | 26 | 83,145.0 | 19 | 78,622.3 | 17 | 4,522.7 | 2 |

[1] 2.1. Эрх бүхий байгууллагын чиг үүрэг

2 2.1.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилтийн удирдлагыг хариуцан ажиллах бөгөөд энэ журмын хүрээнд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ЗГХЭГ | 2,000.0 | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | 1 | - | - |
| 4 | МУЕС | 10,000.0 | 1 | 10,000.0 | 1 | 10,000.0 | 1 | - | - |
| 5 | СоЯ | 5,000.0 | 1 | - | | | | | |
| 6 | ХНХЯ | 1,550.0 | 2 | 950.0 | 1 | 950.0 | 1 | - | - |
| 7 | ХХААХҮЯ | 1,000.0 | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | 1 | - | - |
| 8 | ЭМЯ | 7,960.0 | 5 | 2,800.0 | 1 | 2,800.0 | 1 | - | - |
| 9 | ЭХЯ | 8,491.0 | 3 | 8,491.0 | 3 | 1,000.0 | 1 | 7,491.0 | 2 |
| | **Нийт** | **200,295.5** | **67** | **175,305.5** | **52** | **162,041.8** | **47** | **13,293.7** | **5** |

Зураг, төсөв шаардлагатай ТАХ-ээс 162,041.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47 ТАХ буюу 90% нь зураггүй, 32,419.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ газаргүй, газар чөлөөлөлтийн ажил дуусаагүй байхад ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.

Мөн техникийн нөхцөл авах зайлшгүй шаардлагатай 106,286.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ-нээс 101,734.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ТАХ буюу 96% нь техникийн нөхцөл аваагүй байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих ТАХ-ний 90%-с дээш хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г баталжээ. Гарсан зөрчлийг өмнөх оны хөрөнгө оруулалтын аудиттай харьцуулбал 2 дахин өссөн байна.

**График №1 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ**




Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангахгүй ТАХ-г баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн $29^{1}.2$[3], $29^{1}.2.2$[4]-т заасныг тус тус зөрчсөн байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г НЗД-д эрх шилжүүлснээр НЗД 2022 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/212 дугаар “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” захирамж гаргаж зураг, төсөвгүй ТАХ-ний зураг төсвийн даалгаврыг боловсруулах чиг үүргийг НХОГ ОНӨААТҮГ-т даалгажээ. Энэ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27[5] дугаар зүйлийн 27.5[6] дахь заалтыг зөрчиж хуулиар зөвшөөрөгдөөгүй чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих ТАХ-ний 90% нь зураг төсөв батлуулаагүй, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-г тусгасан байна.

### А.2.4. Хөрөнгө оруулалтын төслийн санал үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан уу?

---

[3] 291.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:

[4] $29^{1}.2.2$.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

[5] 27 дугаар зүйл.Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг

[6] 27.5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ:

Тухайн жилд санхүүжих хөрөнгө оруулалтын төслийн саналд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2[7]-т ТЕЗ түүний бүрэн эрхийг 14.2.1[8], 14.2.2[9], 14.2.4[10]-т уялдуулан боловсруулахаар тусгасан байна.

НЗД Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд нийт 3,394.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 768 ТАХ-ний саналыг салбарын 14 сайдад хүргүүлжээ.

**Хүснэгт №6. 2022 оны төсвийн төсөлд тусгуулахаар санал хүргүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ**

сая.төг

| Д/д | ТЕЗ | ТАХ-ний too, санхүүжих дүн | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шинэ | Төсөвт өртөг | 2022 онд санхүүжих дүн | Шилжих | Төсөвт өртөг | 2022 онд санхүүжих дүн |
| 1 | МУЕС-БТСХ | 8 | 30,546.0 | 22,115.6 | 2 | 16,014.8 | 6,785.5 |
| 2 | ЗГХЭГ | 35 | 70,021.8 | 51,021.8 | 7 | 7,884.0 | 2,138.7 |
| 3 | Шадар сайд | 3 | 16,103.1 | 9,750.0 | - | - | - |
| 4 | БОАЖЯ | 22 | 11,025.9 | 11,025.9 | - | - | - |
| 5 | БХБЯ | 263 | 794,635.2 | 698,608.6 | 41 | 63,597.9 | 27,020.3 |
| 6 | БШУЯ | 104 | 394,491.7 | 229,418.3 | 42 | 136,739.9 | 49,473.5 |
| 7 | ЗТХЯ | 122 | 1,402,844.2 | 949,174.5 | 25 | 32,551.8 | 8,607.5 |
| 8 | УУХҮЯ | 1 | 28,507.1 | 28,507.1 | - | - | - |
| 9 | ХНХЯ | 7 | 5,380.6 | 3,780.7 | 2 | 2,705.0 | 2,600.0 |
| 10 | ХЗДХЯ | 3 | 10,500.0 | 10,500.0 | - | - | - |
| 11 | ХХААХҮЯ | 5 | 29,202.3 | 29,202.3 | 1 | 600.0 | 300.0 |
| 12 | СЯ | 30 | 55,673.9 | 24,359.3 | - | - | - |
| 13 | ЭМЯ | 35 | 256,197.4 | 169,866.0 | 1 | 1,189.0 | 1,000.0 |
| 14 | ЭХЯ | 9 | 28,027.5 | 28,027.5 | - | - | - |
| | **Нийт** | **647** | **3,133,156.7** | **2,265,357.6** | **121** | **261,282.4** | **97,925.5** |

НЗД-аас ТЕЗ нарт хүргүүлсэн саналын 84.2% буюу 3,133,157.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 647 ТАХ нь шинэ, 15.8% буюу 261,284.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 ТАХ нь шилжих ажил байна.

НЗД СС-ын 2018 оны 295[11] дугаар тушаал, 2019 оны 282[12] дугаар тушаалуудыг тус тус үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний саналыг хүргүүлдэг боловч үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаж боловсруулаагүй энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4[13] дэх заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

**Дүгнэлт:** НЗД нь хөрөнгө оруулалтын төслийн саналыг ТЕЗ нарт хүргүүлэхдээ үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоолоогүй байна.

### А.2.5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан уу?

---

[7] 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

[8] 14.2.1.жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;

[9] 14.2.2.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

[10] 4.2.4.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

[11] Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам" болон холбогдох аргачлалуудыг батлах тухай

[12] Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам батлах тухай

[13] 6.2.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх;

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4[14], орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт, айл, өрхийн ариун цэврийн байгууламж, гудамжны тохижилт, нийтийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, шинэчлэл зэргийг тусгахыг хориглож, 22 дугаар зүйлийн 22.2-т "*Энэ хуулийн 13.3, 13.4 дэх хэсэг улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны төсвийн жилээс эхлэн шинээр тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хамаарна*" гэж заажээ.

2022 онд ХАА зохион байгуулсан 134,112.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 86 ТАХ нь 2023 оны төсвийн жилээс хэрэгжих Төрийн хэмнэлтийн хуульд нийцэж буй эсэхийг тодруулахад дараах байдалтай байна.

**Хүснэгт №7. Хэмнэлтийн тухай хуульд хориглосон ТАХ-ний жагсаалт**

**сая.төг**

| **Д/д** | **ХАА зохион байгуулсан газар** | **Нийт ТАХ** | | **Хэмнэлтийн тухай хуульд хориглосон ТАХ** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТАХ тоо | Төсөвт өртөг | Орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, гэрэлтүүлэг, тохижилт | Төсөвт өртөг | Айл, өрхийн ариун цэврийн байгууламж, гудамжны тохижилт | Төсөвт өртөг | Нийтийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, шинэчлэл | Төсөвт өртөг |
| 1 | БГД-ийн ХААА | 8 | 13,372.6 | 3 | 1,820.0 | 1 | 4,500.0 | 1 | 500 |
| 2 | БЗД-ийн ХААА | 8 | 7,980.0 | 1 | 224 | 0 | - | 1 | 1,303.0 |
| 3 | НОСБГ | 2 | 4,500.0 | 0 | - | 1 | 4,000.0 | 0 | - |
| 4 | НХААГ | 30 | 62,540.3 | 2 | 2,223.3 | 2 | 3,406.7 | 3 | 7,500.0 |
| 5 | СХД-ийн ХААА | 13 | 26,237.0 | 1 | 1,000.0 | - | - | - | - |
| 6 | УБЗАА | 25 | 19,482.70 | 1 | 1,000.00 | 1 | 300 | 4 | 8,500.00 |
| | **Нийт** | **86** | **134,112.6** | 8 | 6,267.3 | 5 | 12,206.7 | 9 | 17,803.0 |

Хүснэгтээс харвал 22 ТАХ буюу 25% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцэхээргүй байна.

**Дүгнэлт:** Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримтлан ажилласан байна.

[14] 13.4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

## БҮЛЭГ 2. Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцэж байна уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д шинээр хэрэгжих багц болж задраагүй 206,035.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ-ний эрх шилжин ирснээс 8 багц ТАХ задарч 128 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахаар холбогдох газруудад эрх олгосноос 89,214.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ захирамжаар хүчингүй болж, 12,316.8 сая төгрөгийн төсөвт өртөг 13 ТАХ хөрөнгө татагдаж 177,336.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 96 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

Мөн НХОГ ОНӨААТҮГ болон НЗХГ-ууд 572,826.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 590,839.79 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 206 ТАХ-ний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласнаас 30% нь дуусаж, 26.2% нь эхлээгүй, 7.7% нь зогссон буюу хөрөнгө татагдаж, 36.1 % нь хэрэгжиж байна.

### Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар ТЕЗ-аас НЗД-д төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г эрх шилжүүлснээс ТАХ-ний төсөвлөлтийн шаардлагыг нөхөн хангуулах, зураг төсвийг магадлалаар баталгаажуулах шаардлага үүссэнээс шалтгаалан ХАА-г хугацаа алдан зарлах, гүйцэтгэгчдийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор бүрэн хангаагүй, холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.

### Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг зарласан уу?

УИХ-аас 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтад "Монгол улсын 2022 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж"-ийн жагсаалтын дагуу холбогдох яамдаас Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2[15], Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3[16], ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.3[17]-т заасны дагуу 72 ТАХ-ний эрх шилжүүлснээс 8 ТАХ-г багцад хувааж 128 ТАХ-г холбогдох газруудад эрх шилжүүлсэн байна.

**Хүснэгт №8. Эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо**

Сая/төг

| № | Эрх шилжүүлсэн ТЕЗ | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | санхүүжих дүн | Худалдан авалтын ангилал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ажил | | Бараа | | ЗҮ | |
| | | | | | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо |
| 1 | БХБЯ | 48 | 114,482.2 | 35,088.8 | 110,706.2 | 44 | 2,000.0 | 1 | 500.0 | 1 |
| 2 | БШУЯ | 38 | 101,421.4 | 27,761.0 | 85,111.4 | 23 | 16,310.0 | 15 | | |
| 3 | ЗГХЭГ | 1 | 2,000.0 | 1,000.0 | 2,000.0 | 1 | | | | |
| 4 | ЗТХЯ | 2 | 4,300.0 | 2,309.0 | 4,300.0 | 2 | | | | |

[15] 24.2.Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

[16] 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

[17] Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **5** | МУЕС-БТСХ | 4 | 32,807.2 | 21,330.0 | 32,807.20 | 4 | | | | |
| **6** | СЯ | 9 | 5,000.0 | 5,000.0 | | | 5,000.0 | 9 | | |
| **7** | ХНХЯ | 2 | 1,550.0 | 1,550.0 | 950.0 | 1 | 600.0 | 1 | | |
| **8** | ХХААХҮЯ | 4 | 1,100.0 | 1,100.0 | | 4 | 1,100.0 | | | |
| **9** | ЭМЯ | 18 | 9,102.2 | 6,036.2 | 4,154.7 | 3 | 4,947.5 | 15 | | |
| **10** | ЭХЯ | 2 | 7,491.0 | 3,091.0 | 7,491.0 | 2 | | | | |
| | **Нийт дүн** | **128** | **279,254.0** | **104,266.0** | **247,520.5** | **84** | **29,957.5** | **41** | **500.0** | **1** |

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1[18]-т “*барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд*” эхлүүлэхээр заажээ.

**Хүснэгт №9. ТЕЗ-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа**

***Сая/төг***

| № | ТЕЗ-ын нэр | ТАХ-ний Тоо | ТАХ-ний Төсөвт өртөг /сая.төг/ | *Шилжүүлсэн* хугацаа /хоног-р/ |
|---|---|---|---|---|
| 1 | БХБЯ | 48 | 114,482.2 | 28 |
| 2 | БШУЯ | 38 | 101,421.4 | 26 |
| 3 | ЗГХЭГ | 1 | 2,000.0 | 67 |
| 4 | ЗТХЯ | 2 | 4,300.0 | 32 |
| 5 | МУЕС | 4 | 32,807.2 | 65 |
| 6 | СЯ | 9 | 5,000.0 | 28 |
| 7 | ХНХЯ | 2 | 1,550.0 | 34 |
| 8 | ХХААХҮЯ | 4 | 1,100.0 | 99 |
| 9 | ЭМЯ | 18 | 9,102.2 | 54 |
| | ЭХЯ | 2 | 7,491.0 | 28 |
| | **Нийт** | **128** | **279,254.0** | |

2022 оны төсвийн тухай хууль баталснаас хойш ТЕЗ-аас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж эхлэх нийт 128 ТАХ-г НЗД-д эрх шилжүүлэхдээ 26-99 хоногийн дараа буюу 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хооронд хүргэсэн байна.

**Хүснэгт №10. НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа**

***Сая/төг***

| № | *Эрх шилжсэн газар* | *ТАХ-ний* Тоо | *ТАХ-ний* Төсөвт өртөг /сая.төг/ | *Шилжүүлсэн хугацаа /хоног-р/* |
|---|---|---|---|---|
| 1 | БГД ХААА | 11 | 13,472.6 | 58-102 |
| 2 | БЗД ХААА | 8 | 7,980.0 | 58-69 |
| 3 | БНД ХААА | 5 | 12,021.0 | 58-65 |
| 4 | НД ХААА | 1 | 1,207.0 | 101 |
| 5 | НОСБГ | 6 | 22,413.9 | 66-102 |
| 6 | НӨХГ | 1 | 18,991.4 | 67 |
| 7 | НХААГ | 43 | 112,607.1 | 60-65 |
| 8 | НХОГ | 4 | 14,504.0 | 66 |
| 9 | СХД ХААА | 16 | 45,625.0 | 66-76 |
| 10 | УБЗАА | 33 | 30,432.7 | 48-138 |
| | **Нийт** | **128** | **279,254.7** | |

2022 оны Улсын төсөв батлагдсанаас хойш ТЕЗ-аас НЗД-д эрх шилжсэн 128 ТАХ-ний ХАА зохион байгуулах эрхийг холбогдох харьяа газруудад 58-138 хоногийн дараа шилжүүлжээ.

[18] 46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна: 46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

ТЕЗ-даас эрхийг дээрх байдлаар хугацаа хоцроож шилжүүлж байгаа нь ТАХ он дамжих, төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

ТЕЗ нар ТАХ-г Нийслэлд хугацаа алдаж эрх шилжүүлж байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах боломжгүй байна.

НЗД ТЕЗ-аас эрх шилжиж ирсэн ТАХ-ний жагсаалтыг ХАА зохион байгуулахаар 57 удаагийн захирамжаар 279,254.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 128 ТАХ-г шилжүүлснээс 177,336.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 96 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ХАА-г зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа 15-254 хоногийн хугацаа зарцуулсан байна.

**Хүснэгт №11. ХАА-г зохион байгуулахад зарцуулсан хугацаа**

**сая.төг**

| № | Эрх шилжсэн газар | ТАХ-ний Тоо | ТАХ-ний Төсөвт өртөг /сая.төг/ | ХАА-г зохион байгуулахад зарцуулсан хугацаа /хоног-р/ |
|---|---|---|---|---|
| 1 | БГД-ийн ХААА | 8 | 13,372.6 | 46-241 |
| 2 | БЗД-ийн ХААА | 8 | 7,980.0 | 20-254 |
| 3 | БНД-ийн ХААА | 4 | 8,521.0 | 36-175 |
| 4 | НД-ийн ХААА | 1 | 1,207.0 | 75 |
| 5 | НОСБГ | 2 | 4,500.0 | 54-61 |
| 6 | НӨХГ | 1 | 18,991.4 | - |
| 7 | НХААГ | 30 | 62,540.3 | 41-240 |
| 8 | НХОГ | 4 | 14,504.0 | 15-47 |
| 9 | СХД-ийн ХААА | 13 | 26,237.1 | 36-202 |
| 10 | УБЗАА | 25 | 19,482.7 | 35-197 |
| | **Нийт** | **96** | **177,336.1** | **15-254** |

ХАА-г зохион байгуулахад 1 сараас дээш хугацааг зарцуулсан 134,943.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 85 ТАХ байна. Жишээ нь:

➢ Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 05, 06, 07 дугаар байр, 5 дугаар хороо, Эрэл 47/1, 47/2, 47/3 дугаар байр, 17 дугаар хороо, Ганти 40, Ганти 40В дүгээр байрны нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, төсөвт өртөг 500.0 сая төгрөг- Тендерийн үнэлгээтэй холбоотой гомдол гарснаар дахин зарлагдаж 241 хоног зарцуулсан

➢ Улаанбаатар, СХД дүүрэг Хүүхэд залуучуудын театрын тоног төхөөрөмж багц 2,3,7,8,9 төсөвт өртөг 2,445.3 сая төгрөг– Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт бүрэн боловсруулагдаагүй шалтгаанаар тендерийн баримт бичиг боловсруулах ажил хойшилж 255 хоног зарцуулсан

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжиж ирсэн ТАХ-ний 90% нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4[19]-т заасныг зөрчсөнөөс зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, газрын байршил тодорхойгүй, газар чөлөөлөлтийн асуудлыг шийдээгүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний эрхийг шилжүүлснээс шалтгаалж 55,666.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ-ний ХАА түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр зохион байгуулагджээ. *Хавсралт №2.*

Хугацаа алдсанаас 2022 онд зохион байгуулахаар батлагдсан ТАХ-ний 35 буюу 12.6%-ийн ХАА нь 06 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зарлагдсан, эдгээрээс 8 ТАХ

[19] 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

буюу 7.6% нь бүтээн байгуулалтын ажил зогсох хугацаа буюу 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш гэрээ нь байгуулагдсан байна.

Дээрх байдлууд нь батлагдсан ТАХ хэрэгжихгүй удаашрах эрсдэлийг үүсгэж байна.

**Дүгнэлт** НЗД-д эрх шилжиж ирсэн ТАХ-ний 90% нь зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөлгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс ХАА-хойшлогдож хугацаандаа хэрэгжих боломжгүйд хүрэх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүсэж байна.

## Б.1.2.Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан уу?

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1[20], 47.3[21]-т заасны дагуу захиалагч болон эрх шилжүүлж авсан байгууллага үнэлгээний хороо байгуулж, үнэлгээний хороо ТББ-ийг боловсруулахаар заасан бөгөөд ТББ боловсруулахдаа СС-ын баталсан жишиг баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, агуулга, гэрээний ерөнхий нөхцөл хэсгүүдэд өөрчлөлт оруулаагүй байна. Харин өөрийн эрх хэмжээний хүрээнд ТШӨХ, тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, үе шатны ажлын хуваарь, урилга зэрэг хэсгүүдэд холбогдох өөрчлөлтийг хийдэг байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжиж ирсэн 177,336.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 96 ТАХ-ний ТББ-г боловсруулан баталж ХАА-г зохион байгуулсан байна.

**Хүснэгт №12. Боловсруулсан тендерийн баримт бичиг**

сая.төг

| Д/д | ХАА зохион байгуулсан газар | Баримт бичгийн тоо | Үнэлгээ хийсэн баримт бичиг | Төсөвт өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | БГД ХААА | 8 | 8 | 13,372.6 |
| 2 | БЗД ХААА | 8 | 8 | 7,980.0 |
| 3 | БНД ХААА | 4 | 4 | 8,521.0 |
| 4 | НД ХААА | 1 | 1 | 1,207.0 |
| 5 | НОСБГ | 2 | 2 | 4,500.0 |
| 6 | НӨХГ | 1 | 1 | 18,991.4 |
| 7 | НХААГ | 30 | 30 | 62,540.3 |
| 8 | НХОГ | 4 | 4 | 14,504.0 |
| 9 | СХД ХААА | 13 | 13 | 26,237.1 |
| 10 | УБЗАА | 25 | 25 | 19,482.7 |
| | **Нийт** | 96 | 96 | 177,336.1 |

Тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарь, урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.

Аудитаар ХАА амжилттай зохион байгуулсан 96 ТАХ-ний гүйцэтгэгчийг ТББ-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулсан эсэхийг бүрэн хамруулан тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- СХД-ийн ХААА-наас зохион байгуулсан Усан спорт сургалтын төвийн барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг) төсөвт өртөг 10,000.0 сая төгрөг. *ТББ-ийг СХД-н*

[20] 47.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна

[21] 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох заавриын дагуу гүйцэтгэх;

*ЗД-ын 2022.01.28-ны А/102 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүд боловсруулжээ. ТББ-т ТШЗ 17.6.3-д ажил гүйцэтгэхэд шаардагдах техник хэрэгсэл машин механизмын эзэмшигчийг тодорхой заагаагүй. /түрээсээр эсвэл компанийн өөрийн эзэмшил/ Тус тендерт "Ванхүү ХХК" оролцон гүйцэтгэгчээр шалгарсан;*

- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 240 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо) төсөвт өртөг 4,600.0 сая төгрөг. *ТББ-ийг СХД-н ЗД-ын 2022.02.16-ны өдөр байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүд боловсруулжээ. ТББ-т ямар компани үнийн саналаа ирүүлснийг илтгэх тэмдэглэл байхгүй. Тендерийн нээлт байхгүй тус тендерт Холчжинчин ХХК шалгарсан;*
- БНД-ийн ХААА-аас зохион байгуулсан Ахмадын хөгжлийн төвийн барилга (Улаанбаатар, Багануур дүүрэг) төсөвт өртөг 950.0 сая төгрөг. *ТББ-ийг 2022.01.24-ны А/32 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүд боловсруулжээ. ТББ боловсруулахдаа, боловсон хүчин болон техник, авто машины 50-60 хувь нь үндсэн ажилтан, үндсэн машин, тоног төхөөрөмж байх шаардлагыг заагаагүй байна. Тус тендерт Таван од констракшн ХХК оролцон гүйцэтгэгчээр шалгарсан;*
- НХААГ-аас зохион байгуулсан Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо/ төсөвт өртөг 4,154.0 сая төгрөг. *ТББ-ийг 2022.01.21-ний өдөр байгуулагдсан үнэлгээний хороодын гишүүд боловсруулжээ. ТББ-т Ашиг сонирхлын мэдүүлэгт н.Эрдэнэт, н.Баасансүрэн нар нь ашиг сонирхолтой эсэх талаар бөглөөгүй, барилгын гадна шугам сүлжээний техникийн нөхцөл ТББ байхгүй. Хурлын тэмдэглэл зөрүүтэй, 2 удаа зарлаад шаардлага хангасан компани байхгүй нь шууд гэрээ байгуулах үндэслэл болохгүй* ТБОНӨХБАҮХАТХ-ийн *30.4.1 болон 30.4.2-т заасан өөрчлөлтийг оруулан дахин тендерийг зарлаагүй. Тус тендерт Юувоку ХХК шалгарсан.*
- Эрт илрүүлэг, оношилгооны төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөвт өртөг 1,250.8 сая төгрөг *Ашиг сонирхлын мэдүүлэгт зөрчилтэй эсэх тэмдэглэгээ хийгдээгүй /Д.Батсүх, Б.Лхагважав/, тендерийн нээлтэд Батсүх, Лхагважав нарын гарын үсэг байхгүй;*
- Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг *Ашиг сонирхол зөрчилтэй эсэх бөглөөгүй /н.Эрдэнэт/, ТББ боловсруулсан хурлын тэмдэглэл дээр гишүүдийн гарын үсэг зурагдаагүй.*

Мөн ХАА зохион байгуулсан дараах 4 цэцэрлэгийн барилга буюу ижил төрлийн ТАХ-ний ТББ-ийг хэрхэн боловсруулж байгааг тодруулахад тендерт оролцогчдод тавих шаардлагыг харилцан адилгүй тусгаж, боловсруулсан байна. Үүнд:
НХААГ-аас зохион байгуулсан 4 ТАХ.

- Цэцэрлэгийн барилга, 240 ор. /СХД, 40-р хороо/, Төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг,
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /БЗД, 2-р хороо/, Төсөвт өртөг 3,200.0 сая төгрөг,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, СХД, 23-р хороо/, Төсөвт өртөг 2,882.8 сая төгрөг,
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, СХД, 42 дугаар хороо/, Төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг.

Дээрх 4 ТАХ-ний үнэлгээний хорооны бүрэлдэхүүн нь ТББ боловсруулахдаа зарим ТАХ-д нь борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 30 хувь, 50 хувь зэргээр өөр, ижил төстэй ажлын туршлага төсөвт өртгийн /30 хувь, 50 хувь зэргээр өөр/, ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцөд ус хангамж ариутгах татуургын инженер, халаалт агаар сэлгэлтийн инженер аль нэгэнд байхгүй борлуулалтын орлого зэрэг үзүүлэлтүүдийг харилцан адилгүй тусгасан нь ажлын тоо хэмжээ, төсөвт өртөг ойролцоо тендерийн баримт бичигт ТОӨЗ-ыг ялгавартайгаар боловсруулж батлуулж байгаа нь СС-ын 2014

оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам шинэчлэн батлах” 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “*Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах*” журмын 7.1.1-д заасан “*Үнэлгээний хорооноос боловсруулсан тендерийн баримт бичиг, үнэлгээний дүгнэлтийг хянаж, баталгаажуулах*” үүргээ НХААГ-ын даргын томилсон үнэлгээний хорооны гишүүд хэрэгжүүлээгүй байна.

Үнэлгээний хороод ижил төрлийн ТАХ-ний ТББ-г харилцан адилгүй боловсруулснаас чадваргүй гүйцэтгэгч шалгарах, ТАХ чанаргүй болох, хугацаандаа хэрэгжихгүй байх, хууль журмыг мөрдөж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Төсөвт өртөг болон ангиллын хувьд ижил ТАХ-ний ТББ-ийг боловсруулахдаа тавигдах шаардлагыг харилцан адилгүй тусгадаг нь тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаагүй, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

### Б.1.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаан, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан уу?

ХАА амжилттай зохион байгуулсан 96 ТАХ-ээс 82 буюу 86.0%-ийг нь нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмаар, 13 буюу 13.1%-ийг тендер шалгаруулах онцгой журмаар, 1 буюу 0.9%-ийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар зохион байгуулжээ.

**График №2. ХАА-г зохион байгуулсан журам**




ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.4[22]-д заасны дагуу нийслэл, дүүргийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, НХОГ ОНӨААТҮГ, НЗХГ-ын төлөөлөл, ИТХ-аас томилсон зөвшөөрөл бүхий 36 иргэнийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулж ажилласан байна. Мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2[23]-т заасан тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй байлгах хүрээнд www.tender.gov.mn цахим хуудас болон өдөр тутмын сонинд тендерийн урилгыг нийтэлжээ.

ХАА зохион байгуулж дууссан ТАХ-ний 89 буюу 85.4% нь цахим систем ашигласан байна.

[22] 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.
[23] 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

Гүйцэтгэгч нь сонгон шалгарсан 96 ТАХ-г төрлөөр авч үзвэл машин, техник, тавилга тоног төхөөрөмж 42%, барилга, байгууламж 25%, тохижилт 15%, засвар 10%, дэд бүтэц 6%, бусад 2%-ийг нь эзэлж байна.

**График №3. ТАХ-нд эзлэх хувийн жин, төрлөөр**




Аудитаар 2022 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 177,336.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 96 ТАХ-г бүрэн хамруулан тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

- НХААГ-аас Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо/ төсөвт өртөг 4,154.0 сая төгрөг *Шалгарсан компани болох Юувиси ХХК-ны Ижил төстэй ажилд ирүүлсэн материал шаардлага хангаагүй тухайн ажлаас өөр гүйцэтгэж байгаа 90 хувийн гүйцэтгэлтэй барилгын ажлын зураг болон инженер техникийн ажилчдыг давхцахгүй байх нотлох баримт байхгүй;*
- Эрт илрүүлэг, оношилгооны төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөвт өртөг 2,800.0 сая төгрөг *Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл ТШ317.6.2 Хур системийн лавлагаа ТББ-т байхгүй байхад тендерт шалгаруулсан;*
- УБЗАА-аас Дүүргийн эрүүл мэндийн тоног төхөөрөмж /багц1-8/ төсөвт өртөг 1,970.0 сая төгрөг *Багц1-8 ТББ-н ТШЗ 18.6.3-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. Багц 4-р ажлын ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны хурлаар ТББ-н ТШЗ 18.6.4 дээр 2019-2021 онуудад ижил төстэй бараа нийлүүлсэн мэдээлэл шаардсан гэтэл 2019 оны бараа нийлүүлсэн тодорхойлолт, гэрээ ирүүлээгүй Медиконт ХХК-г шалгаруулсан. Багц 7-р ажил дээр Монтех дистрибьюшн ХХК-г хэрхэн шалгаруулсан талаар хурлын тэмдэглэл архивын баримт бичигт байхгүй.*
- УБЗАА-аас Тоглоомын талбайн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг) төсөвт өртөг 300.0 сая төгрөг *ТББ-н ТШЗ 17.6.2-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. ТББ боловсруулахдаа тендерт оролцогчийн чадавх туршлагын чадварыг сүүлийн 2 жилээр боловсруулсан нь шаардлагыг багаар тавьсан. ТШЗ-18.6 сүүлийн 2 жил буюу 2020, 2021 онуудад төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг 1 удаа нийлүүлсэн байх талаар заасан гэвч шалгарсан Мон фалу консалтинг ХХК нь 2022 онд 50 хувьд хүрэхгүй барааг нийлүүлсэн байхад үнэлгээний хороо шалгаруулсан;*

- БНДХААА-аас Ахмадын хөгжлийн төвийн барилга (Улаанбаатар, Багануур дүүрэг) төсөвт өртөг 950.0 сая төгрөг *ТББ-н 17.6 заалт зөрчигдсөн захиалагчийн тодорхойлолт байхгүй. Шалгарсан компанийн техник хэрэгсэл нь ТББ заагдсан 20 хувь өөрийн бусад нь түрээс ТШЗ 17.6.6 заалт зөрчигдсөн түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс өмнө гэрээ байгуулсан. Гэрээн дээр үнийн дүн байхгүй. ТШЗ 17.6.2 заалт зөрчигдсөн зарим ажилчдын дипломын лавлагааг ХУР системээс аваагүй;*
- СХДХААА-аас Хорооны барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39, 43 дугаар хороо) төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг *Түншлэлийн компани нь ТШЗ 17.6 зөрчсөн байхад* шалгаруулсан байна.

НХААГ, УБЗАА болон СХД, БНД-ийн ХААА-наас 54,830.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмуудыг мөрдөөгүй, ТББ-т тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.3[24] дахь заалтыг зөрчжээ. *Хавсралт №3*

**Дүгнэлт:** Тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод зарласан ч нийт ТАХ-ний 23.9%-ийг холбогдох хууль тогтоомж, журмыг зөрчиж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

## Б.2 Төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?

Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар НХЗГ, НХОГ ОНӨААТҮГ-т 11 ТЕЗ-даас эрх шилжүүлсэн 572,826.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 590,839.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 206 ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг тодруулахад төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний эрх шилжүүлснээс 26.2% нь гэрээний дагуу ажлаа эхлээгүй, 6.8% нь зогссон 2 ТАХ-ний хөрөнгө татагдсан байна.

### Б.2.1. Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн үү?

Аудитад НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 397,992.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 84 барилга, байгууламж барих ТАХ-г хамруулан барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн эсэхийг тодруулахад дараах байдалтай байна.

**Хүснэгт №13. Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ**

Сая/төг

| № | Дүүрэг нэр | Нийт тах | | Барилга, байгууламж | | Эхлээгүй ажил | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо |
| 1 | БГД | 103,489.1 | 31 | 41,842.9 | 10 | 30,272.4 | 5 |
| 2 | БЗД | 83,251.9 | 32 | 56,218.7 | 11 | 23,493.9 | 6 |
| 3 | БНД | 13,745.6 | 14 | 4,575.6 | 3 | 3,500.0 | 1 |
| 4 | БХД | 716.6 | 1 | 108,154.4 | - | - | - |
| 5 | СБД | 102,504.6 | 34 | 80,425.6 | 12 | 2,558.2 | 1 |
| 6 | СХД | 120,937.0 | 40 | - | 28 | 20,737.1 | 6 |
| 7 | НД | 31,728.2 | 5 | 26,761.9 | 4 | 14,072.6 | 2 |
| 8 | ХУД | 47,315.6 | 18 | 37,987.3 | 9 | 16,649.6 | 3 |
| 9 | ЧД | 50,854.7 | 15 | 42,026.1 | 7 | 20,932.8 | 4 |
| 10 | Дүүрэг дамнасан | 13,242.1 | 2 | - | - | - | - |
| | **Нийт дүн** | **567,785.8** | **192** | **397,992.8** | **84** | **132,216.9** | **28** |

[24] 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Барилга, байгууламж барих 84 ТАХ-ний хэрэгжилтийн байдлыг тодруулахад 132,216.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ буюу 33% нь эхлээгүй, 194,889.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 36 ТАХ хэрэгжиж байгаагаас 52,797.2 сая төгрөгийн 5 ТАХ гэрээнд заасан хугацааны дагуу, 31 ТАХ гэрээний хугацааг сунгасан, 13,750.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 ТАХ зогссон, 1,408.9 сая төгрөгийн 1 ТАХ хөрөнгө татагдсан буюу барилга, байгууламжийн нийт ТАХ-ний 77% нь гэрээнд заасан хугацаанд эхлээгүй буюу гэрээний хугацааг сунгажээ.

ТАХ хугацаа алдаж хэрэгжиж байгаа шалтгаан нөхцөлийг ТАХ нэг бүрээр авч үзвэл дээрх ТАХ нь Төсвийн тухай хуулийн 29[25] дүгээр зүйлийн 29.2.2-т "*барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх*"; 29.4-т "*Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана*" гэж заасныг зөрчиж зураггүй, газрын байршил тодорхойгүй, газар чөлөөлөлт бүрэн хийгдээгүй, техникийн нөхцөлийн зөвшөөрөл аваагүй ТАХ-г баталж эрх шилжүүлж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулснаас шалтгаалж гүйцэтгэгч хугацаандаа ТАХ-г хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн байна. Тухайлбал:

- ЭМС-аас 2022 онд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн 1,577.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй "*Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга*" (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо), 1,456.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй "*Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга*" (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо) барих ТАХ нь өнөөдрийн байдлаар зураг, төсөв магадлалаар баталгаажаагүй зураггүй ТАХ-нд НХОГ ОНӨААТҮГ-аас ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон;
- 132,216.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ-ний зураг батлагдаагүй;
- 32,620.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 9 ТАХ-ний газрын асуудал шийдэгдээгүй;
- Газар чөлөөлөлт дуусаагүйгээс УБ СХД 3-р хороонд баригдах 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын ажил анхны гэрээгээр 2021 оны 8 дугаар сарын 20-нд эхэлж, 2022 оны оны 10 дугаар сарын 31-ний өдөр ажил нь дуусах гэрээтэй ч 2024 он хүртэл сунгасан байна.




- БШУС-даас 2022 онд эрх шилжүүлсэн СХД-т баригдсан "*Сургууль, цэцэрлэгийн цогцолбор худалдан авах төслийн үлдэгдэл санхүүжилт*" /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/ нэртэй Сүмт өргөө ХХК-ний хэрэгжүүлсэн 2022 онд санхүүжсэн 1,900.0 сая төгрөгийг тухайн цэцэрлэг, сургуулийн барилгын газрын үнэнд нөхөн олгосон.

[25] 29 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын төсөвлөлт

Аудитаар хэрэгжиж буй барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж буй эсэхийг газар дээр нь тодруулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Зөөврийн усан сан /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ /25, 32-р хороо тус бүр 1, 24-р хороонд 2, 33-р хороонд 3ш/ *нийт 7 ширхэг худаг барихаар гэрээ байгуулсан ч 3 худгийн барилга баригдсан. 4 байршил дээр гадны хөрөнгөөр худаг баригдсан байршил давхацсан тул 3 худгаар гэрээ дүгнэж хаахаар шийдвэрлэсэн*;
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 480 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/ барих *"Жинст цамхаг" ХХК-ний гүйцэтгэж буй барилгын ажлын техникийн нөхцлийг буруу тооцоолсноос шалтгаалан барилгын ажил удааширсан, техникийн нөхцөлөөр ....... төслийн хүрээнд хийгдэж буй дулааны нэгдсэн шугамнаас дулаанд холбохоор техникийн нөхцлийг олгосон бөгөөд өнөөдрийн байдлаар нэгдсэн шугамын ажил дуусаагүйгээс дулааны асуудал үүссэн, гүйцэтгэгч дулааныг захиалагчтай амаар тохиролцож цахилгаан халаагуураар шийдвэрлэхээр төсөвт тусгаагүй 3 ширхэг дизель генератор худалдан авсан, үнийн индекс тооцуулж төсөвт өртөг нэмүүлсэн ч НХОГ ОНӨААТҮГ-ын холбогдох албан туушаалтнууд халаалтын асуудлыг шийдвэрлэх, дахин техникийн нөхцөл гаргуулж барилгын ажлыг дуусгуулах талаар шийдвэртэй арга хэмжээ авч ажиллаагүй;*
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн А байрын барилгыг буулгаж, барих /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо, 134 дүгээр цэцэрлэг/- *ажлын барилгын зоорийн давхрын болон нийт ангиудын хулдаан шалыг технолын горим зөрчиж наасанаас нилэнхүйдээ хуурч овойсон;*
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/-ын ажил нь *Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан барилгын зураг төсөлд тавигдах шаардлага 12.1.1-д "эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх" шалгуурыг зөрчиж газар чөлөөлөлтийн ажил бүрэн дуусаагүй газар дээр барилгын зургийг боловсруулснаас зургийн дагуу тохижилтийн ажил гүйцэтгэх боломжгүйд хүрч захиалагч, зохиогч, гүйцэтгэгч аман хэлцлээр зураг өөрчилж зарим тохижилтийг шилжүүлсэн;*
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо/ -тай *сургуулийн барилгыг гүйцэтгэгч комисс ажиллуулахаар хүсэлт өгсөн. 1 давхрын хана температурын заадсаараа цуурч, ханын өнгөлгөө халцарсан;*
- Таван од констракшн ХХК-ний гүйцэтгэсэн комисс ажилласан "Халуун усны барилга" (Улаанбаатар, Багануур дүүрэг, 4 дүгээр хороо) *нь шилэн пасадны 3 цонх хагарсан, усанд орох өрөөний шүршүүрүүд хугарсан, агаажуулалт муу хийгдсэнээс хананы будаг хууларсан;*
- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо/-нд *Холч жинчин ХХК нийлүүлж НХОГ ОНӨААТҮГ-ын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн НХОГ/БА-2022/05 дугаартай комиссын актаар баталгаажсан ажлын гүйцэтгэлийг шалгахад .... ширхэг суултуур эвдэрсэн, дээврээс дусаал гоожсоны улмаас ангиудын таазны шохой халцарч, халтайсан, ус дуссаны улмаас пракетан шал хөөж, товойсон, ангиудын хаалганы наличник хуурч хугарсан;*
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо)-ын *ажлыг хийх зураг баталгаажаагүй байхад гүйцэтгэгч Нью-Эрхэм ХХК-д ажил эхлүүлэх зөвшөөрөл өгч захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн;*

- Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо)-ын *ажлыг хийх зураг баталгаажаагүй байхад гүйцэтгэгч Элсэн морьт ХХК ажил эхлүүлэх зөвшөөрөл өгч захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн.*

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, байгууламжийн ТАХ-ний төсөвлөлтийн шаардлага хангуулаагүйгээс НХОГ ОНӨААТҮГ-т хэрэгжиж буй 65 ТАХ буюу 77.4%-ийн хэрэгжилтэд нөлөөлж удааширсан байна.

### Б.2.2. Их засварыг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн үү?

Нийслэлийн хэмжээнд НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 33,323.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй их засварын 44 ТАХ байна. Үүнээс 9,500.0 сая төгрөгийн 7 ТАХ эхлээгүй, 8,936.7 сая төгрөгийн 8 ТАХ үргэлжиж, 13,958.4 сая төгрөгийн 28 ТАХ дуусаж, 928.2 сая төгрөгийн 1 ТАХ зогссон байна.

Хэрэгжиж эхлээгүй 13,958.4 сая төгрөгийн 7 ТАХ-ээс 4,418.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4 ТАХ-ний зураг боловсруулагдаж дуусаагүй, 3,084.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 ТАХ оны төгсгөлд гэрээ байгуулагдсан, 1,996.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ дулаалгын материалын хөөсийг шинжлүүлж байгаа зэргээс шалтгаалж эхлээгүй байна.

Аудитаар 8,936.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ-ний хэрэгжилтийг газар дээр нь тодруулахад 1 ТАХ-ний гүйцэтгэл зөрчилтэй байна. Үүнд:

- 52 дугаар сургуулийн барилгын дээвэр, гал тогоо, шалны их засвар (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг) - ажлын гүйцэтгэгч "Цаст оргил констракшн" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2021 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн НХААГ-021/061 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний дагуу засварын ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр гэрээ дуусгахаар байгуулсан ч гэрээг дүгнээгүй байна. Тус ажлын хүрээнд сургуулийн гал тогооны барилгын дотор заслыг ажлыг гүйцэтгэхдээ зурагт өөрчлөлт оруулж хулдаасан шалыг пильта шалаар сольж материалын үнийн зөрүүнд солих шаардлагатай хаалгыг солиогүй, дотор заслын ажил хийгдсэн гэх боловч будаг нь хуурч чанаргүй гүйцэтгэсэн;

Их засварын нийт ажлын 64% нь буюу 13,958.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ хугацаандаа хэрэгжиж дууссан байна.

Мөн НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй 35,885.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 31 тохижилтын ТАХ байна. Үүнээс 18,353.3 сая төгрөгийн гэрээний үнийн 14 ТАХ эхлээгүй, 2,499.9 гэрээний үнийн дүнтэй 6 ТАХ дуусаж 15,032.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 11 ТАХ хэрэгжиж байна.

Хэрэгжиж эхлээгүй 18,353.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 ТАХ зураггүй, мөн 9,223.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 6 ТАХ газрын зөвшөөрөлгүй батлагджээ. Үүнээс шинээр хэрэгжих 4 ТАХ газрын байршил тодорхойгүй, 1 ТАХ өмнө тохижилтын ажил хийгдсэн байршилтай давхардсан, 1 ТАХ-ний газар дээр чацаргана тариалсан байна. Эдгээр ТАХ-г хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт №14. Газрын байршил тодорхойгүй, өөрчлөгдсөн ТАХ-ний жагсаалт**

/сая.төг/

| № | Дүүрэг | ТАХ нэр | Хэрэгжих хугацаа | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Олгосон санхүүжилт | Гүйцэтгэгч компани | Газаргүй шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | СХД | Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13, 15,16 дугаар хороо) | 2022-2023 | 1,250.0 | 1,249.8 | 200.0 | Төрөлх мөрөн ХХК | байршил тодорхойгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2** | БГД | Иргэдэд зориулсан ногоон орчин, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2022-2023 | 990.2 | 990.2 | - | Люксдаймонд ХХК | өмнө нь тохижилт хийгдсэн газар |
| **3** | БГД | Дүүргийн ногоон байгууламж, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2022-2023 | 4,500.0 | 4,100.0 | 400.0 | Кристал инженеринг консракшин ХХК | байршил тодорхойгүй |
| **4** | БГД | Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2022-2023 | 967.7 | 967.7 | - | Цагаантолгойн нуур ХХК Хэрмээдэй ХХК | байршил тодорхойгүй |
| **5** | ЧД | Цэцэрлэг, сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламж (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) | 2022-2023 | 951.1 | 951.1 | - | Веллко инк ХХК | байршил тодорхойгүй |
| **6** | БЗД | Шинэ хөдөө төсөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг) | 2022-2022 | 1,000.0 | 964.8 | 35.2 | Сүвэн уул ХХК | газар дээр чацаргана тариалсан, зураггүй |

Аудитаар хэрэгжиж буй 15,032.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 11 ТАХ-ний тохижилтыг ажлыг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж буй эсэхийг газар дээр нь тодруулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Багануур дүүрэг, 3 дугаар хороо/-ийн ажлыг хийх зураг баталгаажаагүй байхад гүйцэтгэгч "И Пи Эс Групп" ХХК-д ажил эхлүүлэх зөвшөөрөл өгч захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн; зураг өнөөдрийг хүртэл батлагдаагүй бөгөөд хийсэн ажил эхнээсээ хуурч, эвдэрсэн;
- Нийтийн эзэмшлийн орон сууцын гадна талбайн тохижилт /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо/-ын ажлын зураг хийхдээ бусдын эзэмшил газрыг оролцуулан хийсэн боловч тухайн газар чөлөөлөгдөөгүйгээс ажил удааширсан, зургийг захиалагч гүйцэтгэгч тохиролцож өөрчилсөн, зурагт аспальтан зам барихаар төсөвлөсөн байхад цементэн зам тавьсан. Хийгдсэн ажил эхнээсээ эвдэрч, хуурсан;
- Явган хүний зам, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/-ийн ажлын гүйцэтгэгч "Нобле роуд" ХХК нь зургийн дагуу ажил гүйцэтгээгүй байхад хариуцсан инженерүүд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн;
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хаягжуулалт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ийн ажлын зураг баталгаажаагүй байхад "Лед Сити" ХХК-д ажил эхлүүлэх зөвшөөрөл өгч захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн;

НХОГ ОНӨААТҮГ-т эрх шилжсэн их засвар, тохижилтын нийт 75 ТАХ-нээс 21 ТАХ буюу 28% нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсанаас хэрэгжиж эхлээгүй байна.

**Дүгнэлт:** Их засварын ажлын ТАХ-г холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн байна. Харин газартай, зурагтай байх шаардлагатай тохижилтын ажлыг төсөвлөлтийн шаардлага хангаагүй баталж, эрх шилжүүлснээр хэрэгжилтэд нөлөөлж удааширч байна.

### Б.2.3. Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байна уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 7 яамдын ТЕЗ-аас тоног төхөөрөмж нийлүүлэх 28,029.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ний эрхийг шилжүүлснээс шинээр хэрэгжих 24,590.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ шинээр, 3,439.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ шилжих ажил байна.

**Хүснэгт №15. Тоног төхөөрөмж нийлүүлсэн ТАХ**

| № | ТЕЗ | Нийт эрх шилсэн ТАХ | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Шинээр хэрэгжих | | Шилжих | |
| | | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо |
| 1 | БХБС | 300.0 | 1 | 300.0 | 1 | | |
| 2 | БШУС | 15,380.0 | 9 | 13,430.0 | 7 | 1,950.0 | 2 |
| 3 | ЗГХЭГ | 300.0 | 1 | | | 300.0 | 1 |
| 4 | СоС | 5,000.0 | 1 | 5,000.0 | 1 | | |
| 5 | ХНХС | 600.0 | 1 | 600.0 | 1 | | |
| 6 | ХХААХҮС | 100.0 | 1 | 100.0 | 1 | | |
| 7 | ЭМС | 6,349.0 | 5 | 5,160.0 | 4 | 1,189.0 | 1 |
| | **Дүн** | **28,029.0** | **19** | **24,590.0** | **15** | **3,439.0** | **4** |

**/сая.төг/**

Шилжин хэрэгжихээр эрх шилжсэн 3,439.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ нь өмнөх онд дууссан бөгөөд 2022 онд үлдэгдэл санхүүжилтээ авсан байна.

ХХААХҮС-аас эрх шилжүүлсэн 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдаагүй байна.

Шинээр хэрэгжих 14 ТАХ бүгд он дамжин хэрэгжихээр батлагджээ.

Аудитаар шинээр хэрэгжих 37 ТАХ-ний хүрээнд СБД, ЧД-ийн ЭМТ, Ерөнхий боловсролын 8 сургууль, 10 цэцэрлэгт нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжийг баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж буй эсэхийг тодруулахад нийцсэн байна.

**Дүгнэлт:** Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцэж байна.

### Б.2.4. Төсөл, арга хэмжээний "ТЭЗҮ" ангилалд тусгагдсан төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар ТЕЗ-даас НЗД-д ТЭЗҮ ангилалд хамаарах ТАХ-ний эрх шилжүүлээгүй байна.

### Б.2.5. Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ байна уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжсэн 39,796.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35,509.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 ТАХ-ний хэрэгжилт удааширч орхигдсон байна.

**Хүснэгт №16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан хэрэгжилт удааширсан ТАХ**

**сая.төг**

| № | Дүүрэг нэр | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Нийт авсан санхүүжилт | 2022 онд санхүүжих ТАХ-ний тоо | 2022 онд санхүүжих дүн | Хэрэгжиж эхэлсэн хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | БГД | 1 | 996.6 | 928.2 | 912.2 | | | 2019-2022 |
| **2** | БЗД | 3 | 16,965.0 | 14,052.2 | 7,990.9 | | | 2011-2019 |
| **3** | СБД | 4 | 4,120.7 | 3,957.6 | 1,305.1 | 1 | 600.0 | 2011-2023 |
| **4** | СХД | 2 | 1,612.0 | 1,612.0 | 496.5 | | | 2014-2022 |
| **5** | ЧД | 3 | 2,058.1 | 2,058.1 | 1,428.6 | | | 2014-2018 |
| **6** | Дүүрэг дамжин хэрэгжсэн | 1 | 14,044.3 | 12901.5 | 11,600.0 | | | 2012 |
| | **Дүн** | **14** | **39,796.7** | **35,509.5** | **23,733.4** | **1** | **600.0** | |

Дээрх 14 ТАХ-ний гүйцэтгэлд 23,733.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь гэрээний үнийн дүнгийн 66.8% байна.

Эдгээр ТАХ удааширсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- СС-аас эрх шилжүүлсэн 2,253.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Залуучуудын хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын *ажлын гүйцэтгэгч Мөнгөн налуу ХХК-тай 2019 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан бөгөөд өнөөдрийн байдлаар барилгын ажлын зураг баталгаажаагүй, техникийн нөхцөлийн зөвшөөрөл гараагүй байхад барилгын суурийн ажлыг эхлүүлснээс болж суурь усаар дүүрч хальсан, 2020, 2021 онуудад хөрөнгө тавигдаагүй*;
- БХБС-аас эрх шилжүүлсэн Хөгжлийн банкны санхүүжилттэй 754.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “СХД-ийн 10-р хороо, Дулааны ф65/200мм-ийн 924 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил”-ын *гүйцэтгэгч “Назу проперти” ХХК, “Ховдын тулга” ХХК, “Дорнын талст” ХХК-ийн түншлэлтэй 2014 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд ажил гүйцэтгээгүй байхад гүйцэтгэгчид Хөгжлийн банкнаас нийт төсвийн 30% буюу 226.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, өнөөдрийн байдлаар ажил хийгдээгүй гүйцэтгэгч ажил орхиж явсан;*
- ХНХС-аас эрх шилжүүлсэн 287.7 сая төгрөгийн санхүүжилттэй Сүхбаатар дүүргийн Ахмадын сувиллын газрын барилгын төсөл арга хэмжээ /15 дугаар хороо/-ний гүйцэтгэгч *"Голланд байшин" ХХК-д ажлын гүйцэтгэл 90%-тай байхад санхүүжилтийг 100% олгож захиалагчийн хяналтын .... сая төгрөгийг 100% НХОГ ОНӨААТҮГ-т төвлөрүүлсэн. Гүйцэтгэгч шалтгаангүйгээр ажил орхисон;*
- БХБС-аас эрх шилжүүлсэн 14,044.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дүүрэг дамнан хэрэгжиж буй "Бридж констракшн" ХХК-ний “Улаанбаатар хотын Бохир усны Туул-1 коллекторын шугам угсралтын ажил” *нь газар чөлөөлөлтийн улмаас ажил зогссон;*
- БХБС-аас эрх шилжүүлсэн Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороонд хийгдэх 858.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Усан хангамж ф32/150мм 871 метр шугам, ариутгах татуургын ф150/300мм-ийн голчтой 3100 метр шугамын зураг төсөл, *барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгч “Назу проперти” ХХК, “Ховдын тулга” ХХК “Дорнын талст” ХХК-ийн түншлэл, Баянгол дүүрэгт хийгдэх 996.6 сая төгрөгийн “Орон сууцны байруудын дулаалга”-ын ажлын гүйцэтгэгч “Тамгат тайж констракшн” ХХК, Чингэлтэй дүүргийн 13,15 дугаар хороонд хийгдэх 942.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хайлааст орчмын дулааны хангамжийн эх үүсвэр, хатуу түлшний халаалтын тогоо-5ш, ялтсан дулаан солилцуур-3 ком-ын барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгч “Асар өргөө” ХХК, “Буурал сутай” ХХК-ний түншлэл, Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ахмадын сувиллыг өргөжүүлж өвлийн барилга барих ажил”-ын гүйцэтгэгч "Голланд байшин" ХХК, ЗГХЭГ-аас эрх шилжсэн 1,080.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Төрийн үйлчилгээний цогцолборын барилга” /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо/-ын гүйцэтгэгч “Тамгат тайж констракшн” ХХК, БОЯ-аас эрх шилжүүлсэн 10,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажил”-ын гүйцэтгэгч "Органик солюшнс монголиа" ХХК зэрэг 6 ААНБ гэрээний үүргээ зөрчиж ажлыг зогсоосон*;
- БХБС-аас 2014 онд эрх шилжсэн Хөгжлийн банкны эх үүсвэртэй 6,965.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй инженерийн шугам сүлжээ, барилга угсралтын 2 ТАХ *2019 оноос хөрөнгө шийдэгдээгүйн улмаас тус тус удааширсан байна.*

**Дүгнэлт:** НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа нийт ТАХ-ний 7.3%-ийн хэрэгжилт удаашрч зогссон байна.

## Б.3. Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон уу?

Хөрөнгө оруулалтын ТАХ-г батлахдаа хуульд заасан төсөвлөлтийн шаардлагуудыг хангуулаагүй, санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар баталсан зэргээс шалтгаалж ТАХ-ний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг

нэмэгдэх эрсдэл үүсэж  төсвийн мөнгө үр ашиггүйгээр илүү зарцуулагдах үндэслэл болж байна.

### Б.3.1. Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн, холбогдох журам, гэрээнд заасан хугацаанд олгосон уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар нийслэлд нийт  627,138.2  сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 275 ТАХ шинээр болон шилжин хэрэгжиж байгаагаас ТЕЗ-с эрх шилжиж ирсэн 244,910.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 79 ТАХ, НЗД-с эрх шилжиж ирсэн 382,227.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 196 ТАХ тус тус байна. Үүнээс ТЕЗ-с 45 ТАХ-ний 47,081.1 сая төгрөгийн, НЗД-с 196 ТАХ-нд 224,628.36 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгожээ.

Аудитаар НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 192 ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэхийг тулган баталгаажуулалт хийхэд 31,927.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 16 ТАХ-нд 9,553.5 сая төгрөг буюу 6%-38%-ийн санхүүжилт илүү олгосон байна. Тухайлбал:

- “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор” Гүйцэтгэгч: Аглут ХХК, Гэрээний үнийн дүн 4,650.6 сая төгрөг. Ажлын бодит гүйцэтгэл: 20%, Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт: 58%





- “Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/” Гүйцэтгэгч: Мөлүү хээр ХХК, Гэрээний үнийн дүн: 1,790.0 сая төгрөг. Ажлын бодит гүйцэтгэл: 32%, Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт: 56%
- “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Төрийн үйлчилгээний цогцолборын барилга /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо/” Гүйцэтгэгч: Тамгат тайж констракшн ХХК, Гэрээний үнийн дүн: 928.9 сая төгрөг, Ажлын бодит гүйцэтгэл: 30%, Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт: 62% *Хавсралт: №4*

**Дүгнэлт:** Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс хэтрүүлэн олгож гэрээний тусгай нөхцөлийн үүргийг хангуулахгүй байгаа нь төсвийн мөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулахад хүргэж байна.

### Б.3.2. Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан уу? Нэмэлт гэрээ нь хуульд нийцсэн үү?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7[26] дахь заалтыг үндэслэн НХОГ ОНӨААТҮГ-аас 139,051.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 30 ТАХ, НЗХГ-с 20,580.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 12 ТАХ, СХД-ийн захиалагчийн алба ОНӨААТҮГ 992.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ нийт 160,624.2  сая

[26] Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө.

төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 43 ТАХ-нд үнийн индекс тооцуулахаар төсөвт тусгуулжээ. Үүнээс гэрээ байгуулж баталгаажсан нь 91,826.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 24 ТАХ байна. *Хавсралт №5*

**Хүснэгт №17. Үнийн индекс тооцуулсан, нэмэлт санхүүжилт гэрээ байгуулсан ТАХ**

сая.төг

| № | Үнийн индекс тооцуулах ТАХ-ний | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2023 оны төсөвт тусгагдсан | | Гэрээ байгуулсан | | | |
| | тоо | Гэрээний үнийн дүн | тоо | Гэрээний үнийн дүн | Магадлалын нэмэгдсэн дүн | Нийт |
| НЗХГ | 12 | 20,580.2 | 5 | 9,257.5 | 1,040.6 | 10,298.10 |
| НХОГ | 30 | 139,051.1 | 18 | 81,575.9 | 9,508.5 | 91,084.40 |
| СХД | 1 | 992.9 | 1 | 992.9 | 237.6 | 1,230.50 |
| ***Нийт*** | **43** | **160,624.2** | **24** | **91,826.3** | **10,786.7** | **102,613.0** |

Эдгээр ТАХ-үүд нь 3-5 жил үргэлжилж 3-с дээш удаа гэрээ сунгасан, газар чөлөөлөлт хийгдээгүй, санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар батлагдсан, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр ХАА зарлагдаж зураг төсөв магадлалаар ороход төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ-үүд бөгөөд энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4[27] дэх заалтыг анхнаасаа мөрдлөг болгоогүйтэй холбоотой байна.

**Дүгнэлт:** Нэмэлт санхүүжилтийн гэрээг хуулийн шаардлагад нийцүүлэн байгуулсан байна. Харин Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг баримталж төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г баталсан бол нэмэлт гэрээ байгуулахгүй байх бүрэн боломжтой байжээ.

### Б.4 Төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжиж буй ТАХ-ний гүйцэтгэлд захиалагч, зохиогч үе шатны хяналтыг цаг тухайд хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч нийт ТАХ-ний 47.9% нь төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөн удааширч байна.

#### Б.4.1. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллага үе шатны хяналтыг цаг хугацаанд нь, үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Аудитаар НХОГ ОНӨААТҮГ, НЗХГ, НБГ, НЭМГ, СХД-ийн захиалагчийн алба ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа 572,826.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 206 ТАХ-г хэрэгжүүлэх явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 44% нь барилга, 23% нь их засвар, 17% нь ИШС, 16% нь тохижилтын ажил байна. Захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт хэрхэн тавьсан, гүйцэтгэгч илэрсэн зөрчил дутагдлыг хугацаанд биелүүлсэн эсэхийг талбайн журнал болон холбогдох бусад баримт материалын хүрээнд тулган баталгаажуулав.

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан *“Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2[28]-т* захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулж болохоор заажээ. Нийслэлд хэрэгжиж байгаа авто

[27] Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.
[28] 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

зам, гүүр, барилга, байгууламжийн хяналтыг НЗХГ /дүрмийн 3.2[29]/, "НХОГ" ОНӨААТҮГ /дүрмийн 4.3.1[30]/-ууд дүрэмд заасан чиг үүргийн дагуу хэрэгжүүлж байна.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэгдсэнээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад НХОГ ОНӨААТҮГ-ын инженерүүд, зураг төсөв зохиогч нараас хөдөлмөр хамгааллыг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, сорьц дээж авч лабораторид туршилт хийлгүүлэх гэх мэт үүрэг даалгавар зөвлөмжийг өгч ажилласан байна.

Гүйцэтгэгчдээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлснээр ил далд ажлын актыг цаг тухай бүр захиалагч, зохиогч нараар баталгаажуулсан, ажлын гүйцэтгэл, ил болон далд ажлуудыг фото зургаар баталгаажуулж ажилласан байна.

Харин НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 397,992.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 84 барилга, байгууламж ТАХ-ний төсөвлөлтийн шаардлага хангуулаагүйгээс 65 ТАХ буюу 77.4%-ийн хэрэгжилтэд нөлөөлж удааширсан, их засвар, тохижилтын нийт 75 ТАХ-нээс 21 ТАХ буюу 28% нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсанаас хэрэгжиж эхлээгүй байна.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжсэн 39,796.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35,509.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 ТАХ-ний хэрэгжилт удааширч орхигдсон байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжиж буй ТАХ-ний гүйцэтгэлд захиалагч, зохиогч үе шатны хяналтыг цаг тухайд хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч нийт ТАХ-ний 47.9% нь төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөн удааширч байна.

### Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжиж буй ТАХ-ний гэрээг дүгнэж, актаар баталгаажуулж ажилласан байна. Харин гэрээ дүгнэж актаар баталгаажсан ТАХ-ний хөрөнгө бүртгэл хангалтгүй байна.

### Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэж, холбогдох хууль, дүрмийн дагуу дүгнэлт гаргаж, хүлээн авсан уу?

НХОГ ОНӨААТҮГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжсэн 404,552.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 157 ТАХ, ТЕЗ-даас шууд эрх шилжүүлсэн 163,233.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 35 ТАХ буюу нийт 545,777.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 567,785.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 192 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

**Хүснэгт №18. Хэрэгжиж дууссан ТАХ**

сая.төг

| № | Дүүрэг нэр | Дууссан ажил |
|---|---|---|

[29] 3.2. нийслэлийн авто замын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх, урсгал засвар, ашиглалт, арчлан хамгаалалтын ажлыг зохион байгуулж, захиалагчийн болон лабораторийн хяналт тавих, ашиглалтад хүлээлгэн өгөх;

[30] 4.3.1-т үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь улс, нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр хяналт тавих

| | | ТАХ-ний тоо | ТАХ-ний төсөвт өртөг | Гэрээний үнийн дүн | дууссан | Гэрээний үнийн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | БГД | 31 | 103,884.5 | 103,489.2 | 5 | 1,643.8 |
| 2 | БЗД | 32 | 83,252.0 | 83,252.0 | 9 | 10,295.6 |
| 3 | БНД | 14 | 13,827.2 | 13,745.6 | 7 | 1,163.0 |
| 4 | БХД | 1 | 750.0 | 716.6 | 1 | 716.6 |
| 5 | СБД | 34 | 74,814.7 | 102,504.7 | 10 | 18,402.0 |
| 6 | СХД | 40 | 123,582.3 | 120,937.0 | 11 | 27,840.0 |
| 7 | НД | 5 | 32,785.7 | 31,728.2 | 2 | 12,689.3 |
| 8 | ХУД | 18 | 47,535.0 | 47,315.7 | 8 | 4,960.4 |
| 9 | ЧД | 15 | 50,954.6 | 50,854.7 | 2 | 7,256.0 |
| 10 | Дүүрэг дамжин хэрэгжсэн | 2 | 14,391.7 | 13,242.1 | | |
| **Дүн** | | **192** | **545,777.6** | **545,777.6** | **55** | **567,785.8** |

Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй 192 ТАХ-нээс 84,966.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 55 ТАХ буюу 29% нь хэрэгжиж дууссан байна.

**Дүгнэлт:** НХОГ ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ-г хүлээн авах комисс нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэж холбогдох хууль, дүрмийн дагуу дүгнэлт гаргаж, хүлээн авсан байна.

### Б.5.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцсон уу?

Аудитын түүвэрт хамрагдсан НХОГ ОНӨААТҮГ, НЗХГ-уудад 2022 онд 99,365.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 63 ТАХ-ний гэрээг дүгнэж, 5,558.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 6 ТАХ-нд 85.8 сая төгрөгийн алданги тооцоолжээ.

**Хүснэгт №19. Гэрээний үүргийн биелэлт тооцсон ТАХ**

сая.төг

| № | Гэрээ дүгнэсэн ТАХ-ний | | Алданги тооцсон | | Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн |
| НХОГ | 55 | 84,966.8 | 6 | 85.8 | 55 | 4,857.1 |
| НЗХГ | 8 | 14,398.7 | 0 | - | 8 | 701.4 |
| **Нийт** | **63** | **99,365.5** | **6** | **85.8** | **63** | **5,558.5** |

Харин 1,556.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 ТАХ-ний барьцаа хөрөнгө болох 77.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулалгүй гүйцэтгэгчид 100% олгосон байна.

- Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг/
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 3 дугаар хороо/

Мөн гэрээний үүргээ биелүүлээгүй 81%-тай гүйцэтгэсэн ажлаа орхисон “Жинчин гранд” ХХК-ийн 1,980.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Зам талбайн тохижилт, ногоон байгууламж, авто зам, зам засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6,15,18,25,26 дугаар хороо/-ын ажил”-ын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 80.5 сая төгрөг байна.



НХОГ ОНӨААТҮГ-аас хяналт хэрэгжүүлсэн гэрээний тусгай нөхцөл хангуулаагүй Мөнхийн үргэлжлэл ХХК, Цац-Орхон ХХК нарын 77.8 сая төгрөгийн барьцааг барьцаа хөрөнгийн дансанд буцаан байршуулаагүй байна.

**Дүгнэлт:** Төсөл, арга хэмжээний гэрээг зохих журмын дагуу дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулан ажилласан байна.

### Б.5.3. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д шинээр эрх шилжүүлсэн ТАХ-ээс төрийн өмчид бүртгэх 3,500.0 сая төгрөгийн санхүүжилттэй 3 ТАХ-г бүртгээгүй, НӨХГ-т бүртгэгдэх 30,378.0 сая төгрөгийн санхүүжилттэй 26 ТАХ-ээс 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г бүртгэж, “Нийслэлийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу 6,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-ээс 5,514.8 сая төгрөгийн 186 хөрөнгийг байгууллага өөрсдөө бүртгэсэн байна.

Харин нийслэлийн өмчид бүртгэхгүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай нийт 24,232.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 ТАХ байна.

**Хүснэгт №20. Өмч бүртгэл**

сая.төг

| № | Өмч бүртгэх газар | 2021 | | | 2022 | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Төсөв | Санхүүжилт | Тоо | Төсөв | Санхүүжилт |
| 1 | НӨХГ зохион байгуулж бүртгэх | 63 | 46,668.4 | 4,561.4 | 26 | 73,685.6 | 30,378.0 |
| 2 | Нийслэлийн өмчид бүртгэхгүй | 19 | 33,204.5 | 10,921.1 | 32 | 24,232.5 | 6,412.6 |
| 3 | Төрийн өмчид бүртгэх | 2 | 24,989.0 | 5,040.0 | 3 | 28,749.0 | 3,500.0 |
| 4 | Байгууллагууд өөрөө бүртгэх | 11 | 16,930.0 | 15,425.0 | 6 | 6,000.0 | 5,800.0 |
| 5 | Он дамжин хэрэгжих | 25 | 55,327.0 | 16,020.2 | | | |
| | **Нийт дүн** | 120 | 177,118.9 | 51,967.7 | 67 | 132,667.1 | 46,090.6 |

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэгдэх 29 ТАХ-ээс 1 ТАХ буюу 3%-ийг өмчид бүртгэжээ. Холбогдох байгууллагуудын бичиг баримтын бүрдүүлэлтээс шалтгаалж өмчид бүртгэх ажил удаашрсан байна.

Аудитаар техник, тоног төхөөрөмжийн бүртгэл, ашиглалттай холбоотой дараах зөрчлүүд илэрч байна.

- Монхауз ХХК-аас ЧД-ийн цэцэрлэгүүдэд нийлүүлэх тоног төхөөрөмж хүлээн авч тушаалаар бүртгэхдээ нийт 62 нэр төрлийн тоглоом хүлээн авахаас 2 төрлийн 6 ширхэг тоглоом дутуу байхад эрхлэгчийн тушаал гаргаж хөрөнгөд бүртгэсэн;
- ЧД-ийн эрүүл мэндийн байгууллагын барилга ашиглалтад орох болоогүй байхад тоног төхөөрөмж нийлүүлсэн тул хадгалах агуулах сав байхгүй, зарим бараа хамгаалалт тааруу газар хадгалж байгаа төдийгүй нийлүүлэгч Голден мед ХХК-аас 2 аппарат хүлээн аваагүй дутуу байхад хөрөнгөнд бүртгэсэн;
- СХД Хүүхэд залуучуудын театрын барилга ашиглалтад орох болоогүй тоног төхөөрөмжийг барилгын худалдан авах сонгон шалгаруулалттай хамт зарлан шалгаруулснаас тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн бөгөөд хадгалах агуулах сав байхгүй нийлүүлэгч компанийн агуулахад хадгалагдсан зөрчлүүд илэрч байна.

Мөн зарим тоног төхөөрөмж ашиглахгүй бол технологийн хоцрогдолд орох, эд хөрөнгийн элэгдлийн тооцоо хийх зайлшгүй шаардлага гарч хөрөнгө оруулалт үр дүн, үр өгөөж буурахаар байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан ТАХ-ний байгууллагууд өөрсдөө хөрөнгөд бүртгэх ажил хэвийн, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх ажил захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагуудаас шалтгаалж удаашралтай байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар НЗД-д эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих ТАХ-нүүд нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, ЗГ-ын болон салбарын бодлогын баримт бичгүүдэд нийцэж байгаа ч 90% нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г баталсан байна.
2. НЗД-д эрх шилжиж ирсэн ТАХ нь зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөлгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй эрх шилжүүлснээс ХАА хугацаа алдах, хууль журмын дагуу зохион байгуулаагүй нь ТАХ хугацаандаа хэрэгжих боломжгүйд хүрч, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүсэж байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний төсөвлөлтийн шаардлага хангуулаагүйгээс НХОГ ОНӨААТҮГ-т хэрэгжиж буй барилга, байгууламжийн 65 ТАХ буюу 77.4%-ийн хэрэгжилтэд нөлөөлж удааширсан, зарим ТАХ зогссон байна.
4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч нь зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс хэтрүүлэн олгож, гэрээний тусгай нөхцөлийн үүргийг хангуулаагүй, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулахад хүргэж байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний гэрээг дүгнэж актаар баталгаажсан боловч ТАХ-ний хөрөнгө бүртгэл удаашралтай байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

**Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэх зөвлөмжийн санал /ҮАГ-т/:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний саналыг хүргүүлэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримтлан зайлшгүй шаардлагатай ТАХ-ний саналыг хүргүүлэх;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-ний эрхийг шилжүүлэх;
3. Төсвийн тухай хууль батлагдсан даруйд НЗД-д эрх шилжүүлэх ТАХ-ний хугацааг баримталж хэвших;
4. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад, орцны засвар, жишиг гудамж, эко ариун цэврийн байгууламж зэрэг ТАХ-г батлахгүй байх.

**Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж хэвших; /Эрхийг мэргэжлийн байгууллагад нь шилжүүлэх/;
2. Орхигдсон барилга, байгууламжийг дуусгах талаар холбогдох газруудад санал хүргүүлэн ажлын уялдаа холбоог сайжруулж, гэрээний үүргээ биелүүлээгүй ТАХ-ний гүйцэтгэлийг зогсоосон ААНБ-ыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх талаар бодитой арга хэмжээ авч ажиллах;
3. Холбогдох хууль, журмыг зөрчиж худалдан авах ажиллагаа, захиалагчийн хяналтыг алдаатай зохион байгуулсан нийслэл, дүүргийн мэргэжлийн байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудын албаны чиг үүргийн гүйцэтгэлийг сайжруулж, хариуцлага тооцох арга хэмжээ авах.

**НХААГ, УБЗАА, БНД, СХД-ийн ХААА-нд:**

1. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт, материалыг үнэн зөвөөр үнэлэн шаардлага хангасан гүйцэтгэгч сонгон шалгаруулах, ХАА-ны явцад тавих хяналтыг сайжруулан өрсөлдөх тэгш боломжоор хангаж, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж ажиллах;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний ХАА-ны мэдээллийн санг бүрэн хөтөлж, үнэн зөв тайлагнаж хэвших.

**НХОГ ОНӨААТҮГ-т:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож, гэрээний тусгай нөхцөлийг хангуулан ажиллах;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**НИЙСЛЭЛИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо,Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2023.04.14 № 03/2300
танай 2023.04.05-ны № 866-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Нийслэл дэх Төрийн Аудитын газраас "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн (СНАГ-2023/02-НА-СТА) гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тусгайлан өгөх саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ И.БААТАРХҮҮ

1110202277

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ**
**ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас: (976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хуудас: www.ub-procurement.mn

2023.04.13 № 3/642
танай -ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд тайлбар саналыг Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу хүргүүлэв.

1 дүгээр хавсралт: Тайлбар, 7 хуудастай.
2 дугаар хавсралт: Баримт, 114 хуудастай.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар ТБАГУТҮГ
Удирдлага
Газрын дарга
Гомбо-Очир Энхтайван
2023.04.13 15:42

## САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

"НЗД-ын тамгын газраас 2023 оны 04 дүгээр сарын 14-ны 03/2300 дугаар албан бичгээр тайлангийн төсөлтэй танилцан, саналгүй бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

"НХОГ" ОНӨААТҮГ-аас аудитын тайлангийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй.

НХААГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/642 дугаар албан бичгээр ирүүлсэн 10 саналаас 4 саналыг тийм/үгүй, 6 саналыг хүлээж аваагүй, нотлох баримтаар тулган баталгаажуулсан болно.

| Д/д | Ирүүлсэн санал | Саналыг хүлээн авсан эсэх | НТАГ-н тайлбар |
|---|---|---|---|
| Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 04 сарын 13-ний өдрийн 3/642 дугаартай албан бичиг | | | |
| 1 | **Цэцэрлэгийн барилга, 200 ор (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 18 -р хороо**<br>1. Тендер шалгаруулалтыг 2022.02.15-ны өдөр зарлан 2022.03.17-ны өдөр нээхэд материал ирүүлсэн оролцогчдоос шаардлагад нийцсэн нэг ч тендер ирүүлээгүй тул 2022.04.18- ны өдрийн хурлаар гишүүдийн саналаар ТББ-т өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэн дахин зарласан. 2022.04.19- ний өдөр зарлан 2022.05.23-ны өдөр нээлтийг хийхэд мөн шаардлагад нийцсэн нэг оролцогч материал ирүүлээгүй тул 2022.07.01-ний өдрийн хурлаар ТБОНӨХБАУХАТХ-ийн 30.4.1 болон 30.4.2-т заасан өөрчлөлтийг оруулан дахин тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАУХАТХ-ийн 30.4.3-т заасны дагуу гэрээ шууд байгуулах аргаар зарласан болно.<br>2. Ашиг сонирхлын мэдүүлэг хадгаламжийн нэгжийн 34-37 дугаар хуудаст байгаа болно. Хэрэв ашиг сонирхол үүссэн гэж үзвэл шийдвэрлэсэн байдлыг бөглөж гарын үсгээр баталгаажуулах байсан.<br>3. НХОГ ОНӨААТҮГ-с 2022.02.09-ний өдөр ажлын даалгаврыг ирүүлсний дагуу үнэлгээний хороо хуралдан ТББ боловсруулан тендер шалгаруулалтыг зарласан. https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1644849232818 линкээр дамжуулж харна уу.<br>4.Шалгарсан компани болох Юувоку ХХК-нийн БУ19-1824/17 дугаартай тусгай зөвшөөрлийг ирүүлсэн болно. Тусгай зөвшөөрлийн заалт 2.1.1, 2.1.3, 2.2.1, 2.2.2 нэмэлтээр БА3.3, 3.4, 3.5 заалтууд ирүүлсэн. БА-6.4 заалт нь хуучнаар 2.2.2 заалттай байна.<br>5.2022.07.06-ны өдрийн ШШГГ-ын тодорхойлолтыг лавлагаагаар ирүүлсэн болно. | Тийм/Үгүй | 1. 2 удаа зарлаад шаардлага хангасан компани байхгүй нь шууд гэрээ байгуулах үндэслэл болохгүй ТБОНӨХБАУХАТХ-ийн 30.4.1 болон 30.4.2-т заасан өөрчлөлтийг оруулан дахин тендерийг зарлаагүй:<br>2. Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид н.Эрдэнэт, н.Баасансүрэн нар нь ашиг сонирхолтой эсэх талаар тэмдэглэгээг хийгээгүй:<br>3.Архивын нэгжид байхгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ<br>4.5.Шүүхийн шийдвэрийн лавлагаа болон тусгай зөвшөөрлийн заалтын санал тайлбарыг хэлэлцэн аудитын тайлангаас хассан. |
| 2 | **Эрт илрүүлэг, оношилгооны төвийн тоног төхөөрөмж Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг**<br>1. Ашиг сонирхлын мэдүүлэг хадгаламжийн нэгжийн 34-37 дугаар хуудаст байгаа болно. Дахин нягталж үзнэ үү.<br>2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “Тендер нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ, мөн тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж, тэмдэглэл үйлдэнэ.” гэж заагдсаны дагуу дээрх мэдээллийг багтаасан нээлтийн тэмдэглэл үйлдсэн болно. Хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-д энэ хуулийн 26.2-т заасан этгээд, захиалагч байгууллагын төлөөлөгч энэ зүйлийн 26.3- т заасан тэмдэглэлд гарын үсэг зурна гэж заасан бөгөөд тендерийн нээлтийн тэмдэглэлд бүх гишүүн гарын үсэг зурах хууль журам | Тий/Үгүй | 1. Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид бүрэн байгаагүй тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.<br>2. Санал тайлбарыг хэлэлцэн аудитын тайлангаас хассан.<br>3. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл ТШЗ 17.6.2-д хур системийн лавлагааг авахаар заасан байтал архивын нэгжид тус лавлагаа байхгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй |

| | | | |
|---|---|---|---|
| | байхгүй болно. Нээлтийн тэмдэглэлд нээлтэд биечлэн байсан хүмүүс гарын үсэг зурдаг.<br>3. Үнэлгээний хороо үнэлгээ хийхдээ ХУР системээс татсан материалыг үндэслэн үнэлгээг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болно. Тус мэдээлэл нь tender.gov.mn хүний нөөцийн хэсэгт татан авч үнэлгээнд ашигласан. | | |
| 3 | ТББ боловсруулсан №1 дугаартай хурлыг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр хийсэн ба хурлын тэмдэглэлийг үнэлгээний хорооны гишүүд бүгд баталгаажуулан гарын үсэг зурсан болно. Хороо дүүргийн орчныг тохижуулах “Жишиг гудамж тохижилтын төсөл” (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) тендерийн баримт бичгээр бүрдүүлсэн хадгаламжийн нэгжийн 28 дугаар хуудаст гарын үсгээр баталгаажуулсан хэсэг байгаа болно. Баримт 11-21 хуудас. Үнэлгээний хорооны дарга А.Эрдэнэтийн ашиг сонирхлын зөрчилгүй эсэхийг бөглөсөн хуудас хадгаламжийн нэгжийн 31-32 дугаар хуудаст байгаа болно.. | Үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид бүрэн байгаагүй тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй |
| 4 | **Нийтийн эзэмшлийн орон сууцны фасад, тохижилт, засвар (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг)**<br>1.Тус төсөл, арга хэмжээг захиалагч байгууллага НХОГ-аас 2022.02.18-ны өдрийн 3/487 дугаар албан бичгээр ирүүлсэн ажлын даалгаврын дагуу зарлан шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.<br>2.ТШЗ 17.6.5-1-д Төсвийг зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ гэж заасан. Шалгарсан оролцогчийн тендерт ирүүлсэн материалд Төсөвчин Д.Оюун-Эрдэнээр батлуулсан төсөв ирүүлсэн. Шалгарсан оролцогчийн материалын бүлэг 6-ын 2 дугаар хуудас.<br>3.ТШЗ 17.6.5-4-д Ажлын талбайтай танилцсан тэмдэглэлийг фото зургийн хамт ирүүлнэ гэж заасан Шалгарсан оролцогчийн тендерт ирүүлсэн материалын 6 дугаар хэсгийн Хавсралт 29 дүгээр хуудсанд ажлын талбайтай танилцсан тухай ирүүлсэн. Баримт 33-43 хуудас.<br>4.ТШЗ 17.6.5-1-д Зураг төсөл боловсруулах байгууллага нь ижил төстэй зураг төсөл гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлнэ гэж заасан. Шалгарсан оролцогчийн тендерт ирүүлсэн материалын 7 дугаар хэсгийн 1-29 дүгээр хуудсанд ижил төстэй ажлын мэдээлэл ирүүлсэн. | Үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид бүрэн байгаагүй тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй |
| 5 | **Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)**<br>1. Тус төсөл, арга хэмжээний ажлын зураг төсвийг захиалагч байгууллага болох НХОГ-аас 2022.02.21-ний өдөр ирүүлсэн бөгөөд үнэлгээний хороо ЕГ шифр:ИБ-24/2020 дугаартай ажлын зураг, ЕГ шифр: ИБ-24/2020 дугаартай ажлын зургийг хүлээн авч 3 удаа зарлахдаа tender.gov.mn цахим системийн 2022.02.21-нд https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1644849630771 2022.04.15 https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1649342007236, 2022.06.16-нд https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1653355179745 линкийн ТЭЗҮ хэсэгт тус тус байршуулсан болно. Зураг төсөвтэй ажилд ажлын даалгавар шаардлагагүй болно.<br>2. Үнэлгээний хороо үнэлгээ хийхдээ ХУР системээс татсан материалыг үндэслэн үнэлгээг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болно. Тус мэдээлэл нь tender.gov.mn хүний нөөцийн хэсэгт татан авч үнэлгээнд ашигласан. | Үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид зураг төсөв бүрэн байхгүй, ажилчдын боловсролын хур системийн лавлагааг авахаар заасан байтал архивын нэгжид тус лавлагаа байхгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй. |
| 6 | **Биеийн тамир хүүхдийн тоглоомын талбай (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13, 15, 16 дугаар хороо)**<br>1. Тус төсөл, арга хэмжээний 2022.06.03-ны өдрөөс хойш №4 (дахин зарлах тухай), 2022.06.23-ны №5 (дахин зарлах тухай), 2023.08.17-ны №6 (дахин зарлах тухай), 2022.09.02- ны №7 (дахин зарлах тухай), 2022.10.05-ны №8 (гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай), хурлын тэмдэглэлүүдийг бүрэн хавсарган хадгаламжийн нэгж үүсгэн хүргүүлсэн болно.<br>2.Төрөлх мөрөн ХХК барилгын инженер Золбаярын НД-ын лавлагааг хур системээс татахад үндсэн ажилтан байсан. Уг ХХК-ийн захирлын тушаал гаргасан байсан.<br>3.Туслан гүйцэтгэгчийн хувьд тендерийн баримт бичгийн ТШЗ 17.8-д Тендерт “Оролцогч нь туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлэх бол тендерийн үнийн 10 хүртэл хувь байна. Дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд: 1.Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй цахим системээр дамжуулан гэрээ | Тийм/үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд архивын нэгжид хурлын тэмдэглэл байхгүй он сар зөрүүтэй, хур системийн лавлагааг шалгахад инженер Золбаяр нь үндсэн ажлаас гадна давхар ажил эрхэлж байгаа нь лавлагаагаар гарсан тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ. |

| | | | |
|---|---|---|---|
| | байгуулсан байна. Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил үүрэг, гэрээний үнийн дүн, хугацааг тодорхой тусгасан байна. 2.Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна. Туслан гүйцэтгэгч нь Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд уг мэдээллийг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана." гэж шаардсан. Туслан гүйцэтгэгчийн тухайд шаардсан материалаас Бусад чадавхын үнэлгээг үнэлгээнд харгалзан үздэггүй болно | | Туслан гүйцэтгэгч компани болох Стийл проект ХХК 2022 онд татварын өртэй хэсгийг тайлбарыг хэлэлцэн аудитын тайлангаас хассан. |
| 7 | **Цэцэрлэгүүдийн шүдний кабинет тохижилт (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг)**<br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим tender.gov.mn систем ачаалалтай байсан. Уг тендерийн нээлтийг 2022.03.30-ны өдөр нээхэд системийн доголдлоос хур системийн лавлагаа хоосон татагдаж байсныг үнэлгээний хороо үнэлгээнд харгалзан үзэж тендерийн материалд ирүүлсэн ажилчдын мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг үндэслэн хянан үзсэн үнэлгээний асуудлыг үнэлгээний хороогоор хэлэлцэн шийдвэрлэж, уг тендерийн ажлын тоо хэмжээ, төсөв, цаг хугацааг бусад зүйлийг харгалзан үнэлгээг хийсэн | Үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд хур системийн лавлагааг / ажилчдын боловсролын лавлагаа /авахаар заасан байтал архивын нэгжид тус лавлагаа байхгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй |
| 8 | **Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 12,13,14,15,16,17,18,19,27,29 дүгээр хороо)**<br>1.2022.06.27-ны өдрийн №5 хурлын тэмдэглэлээр шаардлага хангаж буй талаар хурлын тэмдэглэлд тусгасан. Мөн тодруулга авахаар шийдвэрлэсэн. 2022.07.05-ны №6 хурлаар тодруулгын хариу ирж гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан.<br>2.Шалгарсан оролцогчийн тендерийн баримт бичгийг цахим 88.4мв багтаамжтай цахим архив үүсгэн хүргүүлсэн болно.<br>3.Тендерийн баримт бичиггүй худалдан авах ажиллагааг Хавсралт зарлахгүй. Тус төсөл, арга хэмжээг НХААГ-ын даргаар 2022.02.18, 2022.05.17, 2022.06.07-ны өдрүүдэд батлуулан цахим системд нийтлэн зарласан. 2022.02.21-ний өдөр https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1644849638706, 2022.04.06-ны https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1649056811560, 2022.05.17-ны https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1652614477423, 2022.06.07-ны https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1653354669113 линкээр тендерийн баримт бичгийг боловсруулан ТББ хэсэгт байршуулсан. | Тийм/Үгүй | 1. Тайлбарыг хэлэлцэн аудитын тайлангаас хассан.<br>2.3. Хүлээлгэн өгсөн цахим архивын нэгжид Шалгарсан оролцогчийн тендерийн баримт бичиг, материал байхгүй үнэлгээний хороодын боловсруулсан ТББ хуулагдсан байна. |
| 9 | **Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар, БЗД 2 дугаар хороо)**<br>1.ТББ-т ТШӨХ ашигтай ажилласан талаар шалгуур үзүүлэлт тавиагүй болно. 2.Үнэлгээний хороо үнэлгээ хийхдээ ХУР системээс татсан материалыг үндэслэн үнэлгээг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болно. Баримт 102-108 хуудас. Тус мэдээлэл нь tender.gov.mn хүний нөөцийн хэсэгт татан авч үнэлгээнд ашигласан. | Үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд хур системийн лавлагааг/ажилчдын боловсролын лавлагаа/ авахаар заасан байтал архивын нэгжид тус лавлагаа байхгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ. |
| 10 | **Цэцэрлэгийн барилга, 150 ор (Улаанбаатар, СХД, 23 дугаар хороо)**<br>Үнэлгээний хороо үнэлгээ хийхдээ ХУР системээс татсан материалыг үндэслэн үнэлгээг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болно. Тус мэдээлэл нь tender.gov.mn хүний нөөцийн хэсэгт татан авч үнэлгээнд ашигласан. Баримт 109- 114 хуудас. | Үгүй | Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд хур системийн лавлагааг / ажилчдын боловсролын лавлагаа /авахаар заасан байтал архивын нэгжид тус лавлагаа байхгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ. |

**Хавсралт №1**

**Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй ТАХ**

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Төсөл, арга хэмжээний ангилал | Хэрэгжих хугацаа | | Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/ | Гэрээний мөнгөн дүн /сая.төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны их засвар, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, 1 дүгээр байр/ | Их засвар | 2022 | 2023 | 1,600.0 | 1,599.0 |
| 2 | Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны их засвар, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | Их засвар | 2022 | 2023 | 4,000.0 | 3,936.0 |
| 3 | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 2, 30, 31 дүгээр байр/ | Их засвар | 2022 | 2023 | 2,100.0 | 2,000.0 |
| 4 | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороо/ | Их засвар | 2022 | 2023 | 2,000.0 | 1,996.0 |
| 5 | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар, гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1, 3, 7, 19, 23 дугаар хороо/ Багц 1- Гадна фасадны засвар | Их засвар | 2022 | 2023 | 1,303.0 | 1,210.0 |
| 6 | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар, гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1, 3, 7, 19, 23 дугаар хороо/ Багц 2- Гэрэлтүүлэг | Их засвар | 2022 | 2023 | 224.0 | 189.0 |
| 7 | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар, гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1, 3, 7, 19, 23 дугаар хороо/ Багц 3- Камержуулалт | Их засвар | 2022 | 2023 | 990.0 | 962.0 |
| 8 | Нийтийн эзэмшлийн орон сууцны засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 05, 06, 07 дугаар байр, 5 дугаар хороо, Эрэл 47/1, 47/2, 47/3 дугаар байр, 17 дугаар хороо, Ганти 40, Ганти 40В дүгээр байр/ | Их засвар | 2022 | 2023 | 500.0 | 482.0 |
| 9 | Нийтийн эзэмшлийн орон сууцны фасад, тохижилт, засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | Их засвар | 2022 | 2023 | 3,000.0 | 2,939.0 |
| 10 | Орон сууцны гадна фасад, дулаалга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 6, 15, 16, 18, 25 дугаар хороо/ | Их засвар | 2022 | 2022 | 2,500.0 | 2,399.0 |
| | **Нийт** | | | | **18,217.0** | **17,712.0** |

**Хавсралт №2**

**Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр ХАА-г зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт**

| № | ТАХ-ний нэр | Төсөвт өртөг /сая.төг/ | ТЕЗ-ийн нэр | ХАА-г зохион байгуулагч |
|---|---|---|---|---|
| 1 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хаягжуулалт (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг) | 1,000.0 | БХБС | УБЗАА |
| 2 | Сургуулийн барилгын өргөтгөл (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, 31 дүгээр сургууль) | 2,600.0 | БШУЯ | УБЗАА |
| 3 | Цэцэрлэгийн барилга, 50 ор (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг) | 1,522.7 | БШУЯ | УБЗАА |
| 4 | Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг (Улаанбаатар, Баянгол дүүрэг) | 520.0 | БХБС | БГДХАА |
| 5 | Иргэдэд зориулсан ногоон орчин, тохижилт (Улаанбаатар, Баянгол дүүрэг) | 1,000.0 | БХБС | БГДХАА |
| 6 | Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг хороо" төсөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг) | 2,500.0 | БХБС | НХААГ |
| 7 | Хүүхдийн тоглоомын талбай (Улаанбаатар, Баянгол дүүрэг) | 973.3 | БХБС | НХААГ |
| 8 | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороо) | 2,000.0 | БХБС | НХААГ |
| 9 | Орон сууцны гадна фасад, дулаалга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 4, 6, 15, 16, 18, 25 дугаар хороо) | 2,500.0 | БХБС | НХААГ |
| 10 | Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон) | 10,200.0 | БШУЯ | НХААГ |
| 11 | Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо) | 3,200.0 | БШУЯ | НХААГ |
| 12 | Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 42 дугаар хороо) | 3,000.0 | БШУЯ | НХААГ |
| 13 | Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 40 дүгээр хороо) | 3,000.0 | БШУЯ | НХААГ |
| 14 | Цэцэрлэгүүдийн шүдний кабинет, тохижилт (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) | 2,000.0 | БШУЯ | НХААГ |
| 15 | Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэл (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 62, 67, 74, 76, 104, 105, 121, 129, 143, 151, 153, Ирээдүй Өнөр, Хөгжил | 1,671.0 | БШУЯ | НХААГ |
| 16 | Хороо, дүүргийн орчныг сайжруулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2, 19, 24 дүгээр хороо) | 4,000.0 | БХБС | НОСБГ |
| 17 | Цэцэрлэгийн барилга, 150 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо) | 2,882.8 | БШУЯ | НХААГ |
| 18 | Ундны усны худаг (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо) | 90.0 | БХБЯ | УБЗАА |
| 19 | Эрт илрүүлэг, оношилгооны төв (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) | 2,800.0 | ЭМЯ | НХААГ |
| 20 | Цэцэрлэгийн барилга, 100 ор (Улаанбаатар, Налайх дүүрэг, 3 дугаар хороо) | 1,207.1 | БШУЯ | НДХААГ |
| 21 | Явган хүний зам, тохижилт (Улаанбаатар, Баянгол дүүрэг) | 1,500.0 | БХБЯ | БГДХААГ |
| 22 | Дүүргийн ногоон байгууламж, тохижилт (Улаанбаатар, Баянгол дүүрэг) | 4,500.0 | БХБЯ | БГДХААГ |
| 23 | "Шинэ хөдөө" төсөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг) | 1,000.0 | ХХААХҮЯ | НХААГ |
| | **Нийт** | **55,666.9** | | |

**Хавсралт №3**

## ТББ-т тусгасан зарим шаардлага хангаагүй гүйцэтгэгчдийн жагсаалт

| № | ХАА зохион байгуулсан | ТАХ нэр | Төсөвт өртөг /сая.төг/ | Гүйцэтгэгч | Зөрчлийн утга |
|---|---|---|---|---|---|
| 1 | СХД | Усан спорт сургалтын төвийн барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг) | 10,000.0 | "Ванхүү" ХХК | Машин механизмын 40-50 хувь нь өөрийн компанийн эзэмшилд байх заалт оруулж өгөөгүй. Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 6 хоногийн дараа гэрээ байгуулна гэж заасан байтал 2 хоногийн дараа 04 сарын 14-ны өдөр гэрээ байгуулсан байна. |
| 2 | СХД | Хорооны барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39, 43 дугаар хороо) | 2,000.0 | "Алтай шар говь" ХХК | Түншлэлийн компани нь ТШЗ 17.6 зөрчсөн байхад шалгаруулсан байна. |
| 3 | БНД | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний барилгажилтын төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн дулаан дамжуулах төв /Улаанбаатар, Багануур дүүрэг/ | 4,691.0 | "Билгүүн од констракшн ХХК | Тендерийн баримт бичгийн ТӨЗ-д заасан Түншлэлийн компанийн боловсон хүчний мэдээлэл байхгүй лавлах |
| 4 | БНД | Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, цахилгааны хуваарилах байгууламж - РП /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1, 3, 4 дүгээр хороо/ | 2,800.0 | "Меса инженеринг " ХХК | Тендерийн баримт бичгийн ТӨЗ-д заасан Түншлэлийн компанийн боловсон хүчний мэдээлэл байхгүй. БНД-ийн ХАА-ны хурлын тэмдэглэлүүд яг ижил нэгнээсээ хуулж тавьсан |
| 5 | БНД | Ахмадын хөгжлийн төвийн барилга (Улаанбаатар, Багануур дүүрэг) | 950.0 | " 'Таван од констракшн" ХХК | ТББ боловсруулахдаа, техник, авто машин болон инженер мэргэжилтнүүдийн 50-60 хувь үндсэн ажилтан байх шаардлагыг оруулаагүй. ТББ-н 17.6 заалт зөрчигдсөн захиалагчийн тодорхойлолт байхгүй. Шалгарсан компанийн техник хэрэгсэл нь ТББ заагдсан 20 хувь өөрийн бусад нь түрээс ТШЗ 17.6.6 заалт зөрчигдсөн түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс өмнө гэрээ байгуулсан. Гэрээн дээр үнийн дүн байхгүй. ТШЗ 17.6.2 заалт зөрчигдсөн зарим ажилчдын дипломын лавлагааг ХУР системээс аваагүй. |
| 6 | БНД | Ус, дулаан дамжлуулах төвийн насосын хүчин чадлыг нэмэгдүүлэх (Улаанбаатар, Багануур дүүрэг) / | 80.0 | "Торго манаг" ХХК | Түргэн хөрвөх чадварын мэдээлэл байхгүй шүүхийн тусгай архивын лавлагаа байхгүй, шүүхийн шийдвэрийн лавлагаа байхгүй, |
| 7 | БГД | Дүүргийн ногоон байгууламж, тохижилт (Улаанбаатар, 9Баянгол дүүрэг) | 4,500.0 | Кристал инженеринг констракшн ХХК | ТББ-н ТШЗ 17.6.2 боловсон хүчний мэдээлэлд цахилгааны инженерийн ажлын туршлага 3 жилд хүрээгүй мөн боловсролын мэдээлэл төрийн ХУР системээс аваагүй. ТШЗ 17.6 Захиалагчийн тодорхойлолт байхгүй. |
| 8 | НХААГ | Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо/ | 4,154.0 | Юувоку ХХК | Ашиг сонирхлын мэдүүлэгт н.Эрдэнэт, н.Баасансүрэн нар нь ашиг сонирхолтой эсэх талаар бөглөөгүй, барилгын гадна шугам сүлжээний техникийн нөхцөл ТББ байхгүй. Хурлын тэмдэглэл зөрүүтэй. 2 удаа зарлаад шаардлага хангасан компани байхгүй нь шууд гэрээ байгуулах үндэслэл болохгүй хуулийн 30.4.1 болон 30.4.2-т заасан өөрчлөлтийг оруулан дахин тендерийг зарлаагүй. Ижил төстэй ажилд ирүүлсэн материал шаардлага хангаагүй 90 хувийн гүйцэтгэлтэй барилгын ажлын зураг болон инженер техникийн ажилчдын давхцахгүй байх нотлох баримт байхгүй. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | НХААГ | Нийтийн эзэмшлийн орон сууцны фасад, тохижилт, засвар (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) | 3,000.0 | Гегатера тех ХХК | Анх тендер шалгаруулахдаа шаардлага хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан төсөвт ажлын даалгаварт дутуу тусгасан, ТШ317.6.5-1,4, ТШ3 17.6.5-6 заасныг зөрчсөн байхад шалгаруулсан байна. |
| 10 | НХААГ | Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 4,253.5 | Баткомплект ХХК | Ажлын даалгавар материалд байхгүй ТЭЗҮ, ажилчдын боловсролын мэдээлэл ХУР-с аваагүй. |
| 11 | НХААГ | Эрт илрүүлэг, оношилгооны төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2,800.0 | Монхауз ХХК | Ашиг сонирхлын мэдүүлэгт зөрчилтэй эсэх тэмдэглэгээ хийгдээгүй /Д.Батсүх, Б.Лхагважав/, ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл ТШ317.6.2 Хур системийн лавлагаа ТББ-т байхгүй байхад тендерт шалгаруулсан |
| 12 | НХААГ | Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13, 15, 16 дугаар хороо/ | 1,250.0 | Төрөлх мөрөн ХХК | ТББ материал дутуу тендерийн урилгаас өмнөх хурлын тэмдэглэл үнэлгээний хорооны тэмдэглэл гм баримт бичиг дутуу байна. 2 дахь тендер зарласнаас хойших хурлын тэмдэглэл байхгүй он сар зөрүүтэй. Барилгын инженер Золбаяр нь үндсэн ажлаас гадуур ажил эрхлэж байгаа нь шаардлага хангаагүй ба өмнө үнэлгээний хурал дээр шалгараагүй Батлокс ХХК дээр мөн ийм шаардлага тавьж хассан байна. |
| 13 | НХААГ | Цэцэрлэгүүдийн шүдний кабинет, тохижилт (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) | 2,000.0 | Голден мед ХХК | Шалгарсан байгууллагын ажилчдын ХУР системийн лавлагаа байхгүй. |
| 14 | НХААГ | Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг) | 3,000.0 | Их эрч ХХК | Ашиг сонирхол зөрчилтэй эсэх бөглөөгүй /Эрдэнэт/, ТББ боловсруулсан хурлын тэмдэглэл дээр гишүүдийн гарын үсэг зурагдаагүй. |
| 15 | НХААГ | Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороо/ | 2,000.0 | Төрөлх мөрөн ХХК | Тендер 4 удаа амжилтгүй болоход дараагийн арга хэмжээг аваагүй шууд болон ТББ өөрчлөх зэрэг арга хэмжээг аваагүй хугацаа алдсан. Шалгарсан компанийн ТББ цахим нэгжид байхгүй. |
| 16 | НХААГ | Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ | 3,200.0 | Мон Фа лү консалтинг ХХК | Ажилчдын боловсролын мэдээлэл ХУР системээс аваагүй |
| 17 | НХААГ | Цэцэрлэгийн барилга, 150 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо) | 2,882.8 | Энхтөгс тэмүүлэл ХХК | Ажилчдын боловсролын мэдээлэл ХУР системээс аваагүй |
| 18 | ЗАА | Дүүргийн эрүүл мэндийн тоног төхөөрөмж багц1-8 | 1,970.0 | Медиконт ХХК , Монтех дистрибьюшн ХХК | Багц1-8 ТББ-н ТШЗ 18.6.3-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. Багц 4-р ажлын ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны хурлаар ТББ-н ТШЗ 18.6.4 дээр 2019-2021 онуудад ижил төстэй бараа нийлүүлсэн мэдээлэл шаардсан гэтэл 2019 оны бараа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | нийлүүлсэн тодорхойлолт, гэрээ ирүүлээгүй Медиконт ХХК-г шалгаруулсан. Багц 7-р ажил дээр Монтех дистрибьюшн ХХК-г хэрхэн шалгаруулсан талаар хурлын тэмдэглэл архивын баримт бичигт байхгүй. |
| 19 | ЗАА | Гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний холболт, шугам сүлжээний шинэчлэл (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг) | 1,000.0 | Нойкрафт ХХК | Үнэлгээний хорооны гишүүн Б.Мөнхбаяр ашиг сонирхлын мэдүүлэг бөглөөгүй. ТББ-н ТШЗ 17.6.2-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. ТББ-г боловсруулахдаа холбогдох гэрээ баримтыг баталгаажуулж ирүүлэхийг шаардаагүй. Шалгарсан Нойкрафт ХХК нь ТШЗ 17.6-т заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн комиссын дүгнэлт ирүүлээгүй байхад шалгаруулсан. Тусгай зөвшөөрлийн хугацаа 2022.11.13-нд дуусахаар байна. |
| 20 | ЗАА | Ундны усны худаг (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо) | 90.0 | Электроплас ХХК | ТББ-н ТШЗ 17.6.2-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. Шалгарсан Электроплас ХХК нь ТШЗ 15.6.1-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй байхад шалгаруулсан ТШӨХ-д БА6-1, БА6-2, БА6-3, БА7-1 гэж шаардсан байхад тус компани нь БА6-1, БА6-2, шаардлага хангаагүй, ТББ-т туслан гүйцэтгэгчийн талаар ТШӨХ боловсруулаагүй. Зургийн компани ТШӨх-д заасан тусгай зөвшөөрлийн баримт ирүүлээгүй. |
| 21 | ЗАА | Тоглоомын талбайн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг) | 300.0 | Мон фалү консалтинг ХХК | ТББ-н ТШЗ 17.6.2-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. ТББ боловсруулахдаа тендерт оролцогчийн чадавх туршлагын чадварыг сүүлийн 2 жилээр боловсруулсан нь чанар муутай гүйцэтгэгч шалгарах боломжтой. ТШЗ-18.6 сүүлийн 2 жил буюу 2020, 2021 онуудад төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа 1 удаа нийлүүлсэн байх талаар заасан гэвч шалгарсан Мон фалү консалтинг ХХК нь 2022 онд 50 хувьд хүрэхгүй бараа нийлүүлсэн байхад үнэлгээний хороо шалгаруулсан байна. |
| 22 | ЗАА | Нийтийн эзэмшлийн орон сууцны фасадны засвар (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7, 2, 30, 31 дүгээр байр) | 2,100.0 | Долоон болдог ХХК | ТББ-н ТШЗ 17.6.2-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. Тендерийн нээлтэд гишүүдийн гарын үсэг зурагдаагүй. |
| 23 | ЗАА | Өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмж /багц1-3/ | 500.0 | Ханжинтранс ХХК, Ашид буян ХХК, "Хасу энержи интернэшнл" ХХК | ТББ-н ТШЗ 17.6.2-т зааснаар ажилчдын сургууль төгссөн ХУР системийн лавлагаа байхгүй. Багц 1 ТШЗ 18.6.2 автомашин нийлүүлсэн худалдах, худалдан авах гэрээ үнийн дүн байхгүй шаардлага хангаагүй. Mazda famillia маркийн автомашины зураг ирүүлээгүй. |
| | | | | | |
| | **Нийт** | | **54,830.3** | | |

**Хавсралт №4**

## Бодит гүйцэтгэлд үндэслэлгүй илүү санхүүжилт олгосон ТАХ-ийн жагсаалт

сая.төг

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Гэрээний дүн /төгрөг/ | Гүйцэтгэгч компани | Гэрээний хугацаа | Гүйцэтгэлийн | | Санхүүжилтийн | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хувь | Дүн /төгрөг/ | Хувь | Дүн /төгрөг/ | |
| 1 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо/ | 2,794.2 | Татах хүч ХХК | 2019.10.25 2019.12.20 2020.12.15 2021.08.01 2021.12.25 2022.08.15 2022.12.01 | 80% | 2,235.0 | 86% | 2,415.0 | 180.0 |
| 2 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо) | 4,650.6 | Аглут ХХК | 2021.08.20 2022.10.31 | 20% | 930.0 | 58% | 2,717.0 | 1,787.0 |
| 3 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/ | 6,775.0 | Морин сувд ххк түншлэл жам ххк-ийн түншлэл | 2021.10.12 2022.12.15 | 40% | 2,710.0 | 58% | 3,959.0 | 1,249.0 |
| 4 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/ | 1,782.1 | Эй ди констракшн ХХК | 2020.09.24 2021.09.15 2021.12.20 2022.12.01 | 83% | 1,479.0 | 90% | 1,600.0 | 121.0 |
| 5 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хорооны цогцолборын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/ | 1,795.2 | Энх бизнес өгөөмж ХХК | 2020.09.07 2021.12.30 2022.10.30 | 82% | 1,472.0 | 88% | 1,587.0 | 115.0 |
| 6 | Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/ | 1,790.0 | Мөлүү хээр ХХК | 2019.09.07 2020.09.15 2021.12.20 2022.06.01 2022.12.20 | 32% | 573.0 | 56% | 1,000.0 | 427.0 |
| 7 | Бага сургууль, цэцэрлэгийн | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цогцолборын барилга, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 19 дүгээр хороо/ барих ажил | 3,474.6 | Саран инж девелопмент ХХК | 2019.08.15<br>2020.08.10<br>2020.12.10<br>2021.07.01<br>2022.08.01<br>2022.12.30 | 79% | 2,745.0 | 93% | 3,238.8 | 494.0 |
| 8 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/ | 1,376.6 | Танан цамхаг констракшн ХХК болон Зэндмэнэтулга ХХК-иудын түншлэл | 2021.11.10<br>2022.09.01<br>2022.12.31 | 40% | 551.0 | 57% | 780.0 | 229.0 |
| 9 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Төрийн үйлчилгээний цогцолборын барилга /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо/ | 928.9 | Тамгат тайж констракшн ХХК | 2018.10.03<br>2019.08.21<br>2020.10.01 | 30% | 279.0 | 62% | 580.0 | 301.0 |
| 10 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71-р сургууль | 3,157.2 | СТНАА ХХК | 2019.09.17<br>2020.08.25<br>2021.08.01<br>2021.12.20<br>2022.08.22<br>2022.10.01 | 75% | 2,368.0 | 85% | 2,681.4 | 313.0 |
| 11 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо/ | 4,050.5 | Агардүнз ХХК, Сэхүүн чоно ХХК-ийн түшлэл | 2019.12.26<br>2020.08.01<br>2021.09.01<br>2022.10.01<br>2023.09.01 | 42% | 1,701.0 | 49% | 2,000.0 | 299.0 |
| 12 | Хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажил | 9,793.2 | "Органик солюшнс монголиа" ХХК | 2012.08.30<br>2013.12.25<br>2014.12.31 | 30% | 2,938.0 | 58% | 5,722.0 | 2,784.0 |
| 13 | Дүүргийн спорт цогцолбор 1000 суудал /УБ, БЗД/ | 11,014.8 | Атимос трейд ХХК | 2014.01.15<br>2015.09.01<br>2017.12.31<br>2018.12.31<br>2022.12.30 | 80% | 8,812.0 | 87% | 9,599.0 | 787.0 |
| 14 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх | 1,409.0 | Итгэлт-Өргөө ХХК | 2019.08.21<br>2019.12.20<br>2020.12.04<br>2021.12.01<br>2022.09.01<br>2023.08.23 | 70% | 986.0 | 84% | 1,189.6 | 203.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүрэг,13 дугаар хороо, 172 дугаар цэцэрлэг/ | | | | | | | | |
| 15 | Орон сууцын байруудын дундах тохижилт (Улаанбаатар, Багануур дүүрэг, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84 дүгээр байр) | 331.4 | Өнгөт харш ХХК | 2021.08.27<br>2021.10.27<br>2021.12.15<br>2022.07.01<br>2022.11.30 | 66% | 219.0 | 78% | 259.6 | 41.0 |
| 16 | Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг/ | 716.6 | Мөнхийн үргэлжлэл ХХК | 2021.06.17<br>2021.08.09<br>2021.10.01<br>2021.12.01<br>2022.12.30 | 100% | 717.0 | 100% | 716.6 | - |
| 17 | Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг хороо" төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2,443.3 | Их-эрч ХХК | 2022.04.14<br>2022.12.31 | 79% | 1,930.0 | 88% | 2,154.0 | 224.0 |
| 18 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 3 дугаар хороо/ | 839.6 | Цац-Орхон ХХК | 2022.06.06<br>2022.08.31<br>2022.12.15<br>2023.07.01 | 100% | 840.0 | 100% | 840.0 | - |
| | **Нийт** | | | | | **33,485.0** | | **43,039.0** | **9,554.0** |

**Хавсралт№ 5**

**Үнийн өсөлтийн санхүүжилт авах нэмэлт гэрээ байгуулах төсөл арга хэмжээний мэдээлэл**

| № | Захиалагчийн хяналт | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг /сая.₮/ | Гэрээний дүн /сая.₮/ | Гүйцэтгэгч | Үнийн өсөлтийн дүн /сая.₮/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | НЗХГ | Улаанчулуутын автобусны эцсийн буудлаас Алтан овоо, Алтан овооноос Буяны замын тегсгел хүртэлх хатуу хучилттай авто зам, 4 км /Улаанбаатар,Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо/ | 1,469.2 | 3,557.2 | "Тэмүүн холидинг" ХХК | 14.5 |
| 2 | НЗХГ | Толгойтын замаас Хүнсчдийн гудамжтай холбох хатуу хучилттай авто зам, 0.8 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/ | 1,394.8 | 1,198.8 | "Тэмүүн холидинг" ХХК | 194.8 |
| 3 | НЗХГ | Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам, 1.0 км /Улаанбаатар, Сонгинохайрхан, дүүрэг, 24 дүгээр хороо/ | 1,644.8 | 249.3 | "Заабар" ХХК | 249.3 |
| 4 | НЗХГ | Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх авто зам, 1.7 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | 2,742.6 | 2,277.8 | "Дэд бүтэц консалт" ХХК | 464.8 |
| 5 | НЗХГ | Хорооллын авто замын шинэчлэл, өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13, 14, 15 дугаар хороо/ | 2,091.6 | 1,974.4 | "Голден дрийм" ХХК | 117.2 |
| 6 | СХД | Орон сууцын фасадын дулаалга, дээврийн их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17 дугаар хороо/ | 1,230.5 | 993.0 | Энх төгс тэмүүлэл | 237.6 |
| 7 | НХОГ | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо/ | 3,298.8 | 2,835.0 | Улаанбаатар барилга ХХК , | 463.8 |
| 8 | НХОГ | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/ | 3,687.3 | 3,454.4 | Хан-Аттрибут ХХК | 180.8 |
| 9 | НХОГ | Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн оюутны дотуур байрны барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг/ | 12,950.5 | 11,849.7 | Химон ХХК 99111704 | 1,100.8 |
| 10 | НХОГ | Сургуулийн барилга, 1200 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 2 цогцолбор/ | 10,835.8 | 9,614.9 | Вишн деволопмент ХХК | 1,138.8 |
| 11 | НХОГ | Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/ | 4,577.9 | 3,693.6 | Глобалрост ХХК 99115918 | 577.9 |
| 12 | НХОГ | Сургуулийн барилга, 480 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/ | 6,381.6 | 5,704.5 | Жинст цамхаг ХХК | 529.8 |
| 13 | НХОГ | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/ | 7,145.5 | 6,526.4 | Бумбод ХХК | 619.1 |
| 14 | НХОГ | Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/ | 6,006.8 | 5,610.3 | Ванхүү ХХК | 396.4 |
| 15 | НХОГ | Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/ | 7,593.9 | 6,507.5 | Дарцагт ноёд групп | 1,086.3 |
| 16 | НХОГ | Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ | 7,853.3 | 6,228.1 | МВС ХХК | 1,353.3 |
| 17 | НХОГ | Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/ | 5,762.3 | 5,415.8 | Солид констракшн ХХК | 346.4 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 18 | НХОГ | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо/ | 2,023.4 | 1,802.9 | Дэрэн наран ХХК | 220.4 |
| 19 | НХОГ | Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо/-1 | 1,932.2 | 1,798.8 | "Бөртэ трейд" ХХК | 165.7 |
| 20 | НХОГ | Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Гангар инвест/ | 4,279.6 | 3,472.79 | Ганмөнхжин ХХК | 806.8 |
| 21 | НХОГ | Цэцэрлэгийн барилга, 250 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/ | 2,569.8 | 2,417.00 | Инжхами ХХК 99993398 | 150.1 |
| 22 | НХОГ | Сургуулийн спорт заалны өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 105 дугаар сургууль/ | 1,124.4 | 1,050.4 | Мета менежмент ХХК | 64.4 |
| 23 | НХОГ | Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/ | 1,703.1 | 1,674.3 | Хөх-Үзүүр ХХК | 28.7 |
| 24 | НХОГ | Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, Богд-Ар хороолол/ | 2,197.7 | 1,918.8 | Түмэн-Алт ХХК | 278.8 |
| | | **Нийт** | **102,497.4** | **91,826.3** | - | **10,786.7** |